

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2022 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР
/ЛХАГВА ГАРАГ/-ИЙН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН ТОВЬЁГ**

№	Баримтын агуулга	Хуудас
1.	Хуралдааны товч тэмдэглэл:	1-12
2	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл	13-56
	1.Эрдэнэсийн сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт нарын 4 гишүүн 2020.01.13-ны өдөр мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	13-23
	2.Олон улсын хямралт нөхцөл байдлаас үүдэлтэй гол нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд /Засгийн газар 2022.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	24-52
	3.Түр хороо байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл	52-56

ХУРААНГУЙ ТЭМДЭГЛЭЛ

Хоёр.Олон улсын хямралт нөхцөл байдлаас үүдэлтэй гол нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, Монголбанкны Мөнгөний бодлогын газрын захирал Б.Баярдаваа, Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын захирал А.Энхжин нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Н.Мөнхзэсэм, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа, Б.Ууганцэцэг нар байлцав.

Олон улсын хямралт нөхцөл байдлаас үүдэлтэй гол нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Ж.Ганбаатар: 1.Төслийн гарчгийн “Олон улсын хямралт нөхцөл байдлаас үүдэлтэй” гэснийг хасах. Энэ саналтай холбогдуулан төслийн 1.1 дэх хэсэгт заасан хуулийн зорилгод байгаагаас бусад төслийн зүйл, хэсэг, заалтад байгаа “олон улсын хямралт нөхцөл байдлаас үүдэлтэй” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	1
Бүгд:	12

91.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 5.1 дэх хэсгийн “банктай хамтран” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	1
Бүгд:	12

91.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 5.1.1 дэх заалтын “банкаар дамжуулан олгох” гэснийг “банкны эх үүсвэрээр олгох” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 1

Бүгд: 12

91.7 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төслийн 5.1.2 дахь заалтын “хөнгөлөлттэй санхүүжилтийг банкаар дамжуулан” гэснийг “санхүүжилтийг репо арилжааны нөхцөлөөр банканд” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 1

Бүгд: 12

91.7 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Төслийн 5.1.3 дахь заалтыг “санхүүгийн үүсмэл хэрэгсэл ашиглан энэ хуулийн 3.2.1-д заасан бараа, бүтээгдэхүүний импортод шаардлагатай гадаад валютыг ханшийн эрсдэлийг бууруулж импортлогчдод нийлүүлэх бөгөөд банк энэ эх үүсвэрээр ашиг олох зорилгоор арилжаа хийхийг хориглох;” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд, Ц.Цэрэнпунцаг нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Монголбанкны Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын захирал А.Энхжин нар хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 1

Бүгд: 12

91.7 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Төслийн 6.1.2 дахь заалтын “жилийн батлагдсан нэгдсэн төсвийн нийт зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр төсөв хооронд, төсвийн ерөнхийлөн захирагч хооронд, хөрөнгийн болон урсгал зардал хооронд төсвийн зохицуулалт хийх замаар шийдвэрлэх” гэснийг “тухайн жилийн төсөвт тусган шийдвэрлэх” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэгийн тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 1

Бүгд: 12

91.7 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Төслийн 6.1.3 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 1
Бүгд: 12
91.7 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Төслийн 6.1.5 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 1
Бүгд: 12
91.7 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Төслийн 6.1.1, 7.1.1 дэх заалтын “бүтээгдэхүүний” гэсний дараа “үнийн өсөлт,” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 1
Бүгд: 12
91.7 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Хууль, тогтоолын хүчин төгөлдөр болох хугацааг 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдрөөс гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 1
Бүгд: 12
91.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал:

Ж.Ганбаатар: 1.Төслийн гарчигт “төрлийн” гэсний дараа “зарим” гэж, 5.1, 6.1, 7.1, 8.1 дэх хэсгийн “хэрэгжүүлнэ:” гэсний өмнө “авч” гэж, 5.1 дэх хэсгийн “гол” гэсний өмнө “энэ хуульд заасан” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 1
Бүгд: 12
91.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 3.1 дэх хэсгийн “эдгээр бүтээгдэхүүнтэй хамаатай” гэснийг “эдгээртэй холбогдсон” гэж, 3.2 дахь хэсгийн “доор дурдсан” гэснийг “заасан гол нэр төрлийн зарим” гэж, мөн хэсгийн “бүтээгдэхүүн” гэснийг “бүтээгдэхүүнд дараах бараа, бүтээгдэхүүн” гэж, 7, 8 дугаар зүйлийн гарчгийн “байгууллагын” гэснийг “байгууллагаас” гэж, 8.1.1, 8.1.2 дахь заалтын “хуульд заасан зохицуулалтад хамрагдсан” гэснийг “хуулийн 3.2.2, 3.2.3-т заасан” гэж, 8.1.1 дэх заалтын “хүнсний хангамж,” гэснийг “хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт, хангамж,” гэж, 7.1.2, 8.1.3 дахь заалтын “мөрдүүлэх” гэснийг “, биелэлтийг ханган ажиллах” гэж, 6.1.6 дахь заалтын “мөрдүүлэх ажлыг зохион байгуулах” гэснийг “, биелэлтийг хангуулан ажиллах” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 1
Бүгд: 12
91.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн зүйл, хэсэг, заалт хасагдсантай холбогдуулан дугаарлалтыг өөрчлөх болон төслийн агуулгыг хөндөхгүйгээр хууль зүйн техникийн болон найруулгын шинжтэй засвар хийх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 1
Бүгд: 12
91.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Хоёр.Олон улсын хямралт нөхцөл байдлаас үүдэлтэй гол нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийн хомстол, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийг оруулъя. Төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Булгантуяа гишүүн хийнэ. Булгантуяа гишүүнийг танилцуулга хийхийг урья.

Төсвийн Байнгын хорооны санал, дүгнэлтийг Хүрэлбаатар гишүүн уншиж байж болох юм байна. Ажлын хэсэг сая хуралдаад гүйцэж арай дуусаагүй байгаа юм. Дөнгөж сая дууссан. Та уншиж байя.

Хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Төсвийн байнгын хорооны дарга, Их Хурлын гишүүн Хүрэлбаатар хийнэ. Хүрэлбаатар гишүүний микрофоныг өгье.

Ч.Хүрэлбаатар: Байнгын хорооны дарга, Байнгын хорооны эрхэм шүү дээ. Монгол Улсын засгийн газраас 2022 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Олон улсын хямралт нөхцөл байдлаас үүдэлтэй гол нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3 дахь хэсэгт заасныг үндэслэн Төсвийн байнгын хороо 2022 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Төсвийн байнгын хороо дээрх хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу төслийг зүйл бүрээр нь хэлэлцсэн болно. Байнгын хорооны хуралдааны хуралдаанаар хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүд гол нэр төрлийн бүтээгдэхүүний хүрээ хязгаарыг нэмэгдүүлэх боломжтой эсэх, үнийн өсөлтийг хэрхэн хязгаарлах, бүтээгдэхүүний хангалт, нийлүүлэлт, нөөц бүрдүүлэлтийн талаар болон хомстлоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Хууль, тогтоолын төслийн талаар Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй болно. Ажлын хэсгийн санал хураалт Эдийн засгийн байнгын хороон дээр хураагдана гэж үзсэний үндсэн үндсэн дээр гишүүд зарчмын зөрөөтэй санал гаргаагүй болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Олон улсын хямралт нөхцөл байдлаас үүдэлтэй гол нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг хийсэн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Ж.Ганбаатар: Ажлын хэсгийн ахлагч Булгантуяа гишүүн танилцуулга хийе.

Х.Булгантуяа: Байнгын хорооны дарга эрхэм гишүүд ээ,

Засгийн газраас Монгол Улсын Их Хуралд 2022 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр олон улсын хямралт нөхцөл байдлаас үүдэлтэй гол нэр төрлийн бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомсдлоос сэргийлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төслийг нэн яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн байгаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы 2022 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар дээрх хуулийн төслийн хэлэлцэх хэсгийг хийж, хэлэлцэхийг дэмжсэн. Уг хуулийн төслийг чуулганаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийг төсөл боловсруулах, үүсээд буй хямралт нөхцөл байдлыг шийдвэрлэх, бодлогын шийдэл гаргах, хэмнэлтийн горимд шилжих чиглэлээр төсөвт тодотгол хийх, холбогдох хууль, тогтоол, хөтөлбөрт өөрчлөлт оруулах төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын даргын 2022 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн 48 дугаар захирамжаар байгуулсан. Ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа ахалж, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар, Т.Доржханд, Б.Пүрэвдорж, Ч.Ундрам, Ч.Хүрэлбаатар, Б.Чойжилсүрэн, С.Чинзориг нарын бүрэлдэхүүнтэйгээр ажилласан.

Ажлын хэсэг 2022 оны 4 дүгээр сарын 10, 12, 13-ны өдрүүдэд хуралдаж хуулийн төсөлтэй холбогдуулан дараах зарчмын зөрүүтэй санал гаргалаа.

Хуулийн төслийн гарчгийн “Олон улсын хямралт нөхцөл байдлаас үүдэлтэй” гэснийг нь хасах. Төслийн 6.1.3, 6.1.5 дахь заалтууд нь Улсын Их Хурлын эрх мэдэлд хамаарах асуудал тул төслөөс хасах, 5.1.1 дэх заалтын “банкаар дамжуулан олгох” гэснийг “банкны эх үүсвэрээр олгох” гэж, 5.1.2 дахь заалтыг “хөнгөлөлттэй санхүүжилтийг банкаар дамжуулна” гэснийг “санхүүжилтийг репо арилжааны нөхцөлөөр банканд” гэж тус тус өөрчлөх, хуулийг дагаж мөрдөх хугацааг 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлэх зэрэг зарчмын зөрүүтэй арван санал болон найруулгын шинжтэй бусад саналуудыг Байнгын хороонд оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэж ажлын хэсэг үзсэн байгаа.

Ажлын хэсгийн зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг та бүхэнд тараасан. Хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Ж.Ганбаатар: Булгантуяа даргад баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя. Болдын Жавхлан Сангийн сайд, Загджавын Мэндсайхан Хүнс, хөдөө аж ахуйн сайд, Ёндон Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Лхагвасүрэн Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ганбат, Баярдаваа Монголбанкны Мөнгөний бодлогын газрын writer.chimege.mn яриаг бичвэрт хөрвүүлэв.

захирал, Нандинжаргал Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Сүх-Очир, Тэлмүүн Сангийн яамнаас оролцож байна. Батжаргал Эдийн засгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Батжаргал дарга байна уу? Сая харагдаж байсан даа. Түмэндэлгэр Эдийн засгийн хөгжлийн яамны хөгжлийн судалгаа шинжилгээний газрын дарга гэсэн ийм бүрэлдэхүүнтэй байна.

Ажлын хэсгийн танилцуулга болон Төсвийн байнгын хорооны санал дүгнэлтээс асуух асуултдаа их хурлын гишүүд нэрсээс өгөхийг хүсье. Хүрэлбаатар гишүүнээр тасаллаа. Би хамгийн сүүлд нь асуулт асууна. Даваасүрэн гишүүн асуулт асууя.

Ц.Даваасүрэн: Би хэлэлцэх эсэх дээр хоёр зарчмын санал хэлсэн юм. Тэгээд энэ дээрээс харахаар байхгүй л юм шиг байгаа юм. Шатахууны компаниуд дээр валютын зөрүү гэх юм уу, арай өөр ханшаар олгоод байдаг юмыг чинь Алтанхуягийн Засгийн газрын үед тэглэсэн байхгүй юу. Тэгээд олигтой үр дүн гараагүй юм. Яагаад гэвэл тэртээ тэргүй өсчихсөн валют, нэг л өдөр тэр өссөн үнээр шатахуун зарна шүү дээ. Тэгэхээр зүгээр л цаг хугацааны л асуудал байхгүй юу. Одоо ингээд энэнээс хойш дандаа 2700, 2800- зуугаар зарна гэж байхгүй шүү дээ, 1 долларыг. Тэр өссөн ханшаар л зарна шүү дээ хэзээ нэг өдөр. Тийм учраас энэ нэг зөрүү олгоод байгаа юм чинь бол урт настай эд биш, нэг өдөр ахиад шок дагуулдаг л байхгүй юу даа. Одоо би амьдрал дээр бас юм хэлээд байна шүү дээ. Алтанхуягийн Засгийн газар яг тэгсэн. Тэгээд хоёр жилийн настай ч болоогүй шүү дээ. Нэг жилийн настай л ийм хууль болсон тэр нь.

Хоёр дахь нь бол гурилын үйлдвэрүүдэд татаас хөнгөлөлттэй зээл олгоод хэрэг байхгүй юу. Тэгэх юм бол та нар газар тариалан эрхлэгч компаниудаа дуусгана. Тэд нар чинь гаднаас хөнгөлөлттэй ханшаар баахан будаа оруулж ирээд л, тэгээд нөгөө будаа үйлдвэрлэсэн, одоо будаагаа нөөцөлчихсөн байгаа, зарж чадахгүй байгаа газар тариалан эрхлэгч нар чинь дуусах байхгүй юу. Хэрвээ газар тариалан эрхлэгчдээ бид нар одоо байгаа тэр будааг нь худалдаж аваад тэд нарыг хөнгөлөлттэй зээл өгөөд хямдхан шатахуунаар будаа тариулчих юм бол ирэх хавар бид нар дотоодоосоо 2023 оноо хангаад явчих байхгүй юу. Хэрвээ өнөөдөр ингээд гурил үйлдвэрлэгч нартаа зээл олгочих юм бол 2023 онд, 2024 онд бид нар хямраад л дуусна. Яагаад гэвэл Украин мэдээж хэрэг одоо энэ дайны нөхцөл байдал ямар тариа ногоо тарих юм. Тэгэхээр ийм зүйлийг бид нар жоохон хэлэлцүүлгийн явцад бодитой хармаар байгаа юм.

Өнөөдөр бол Араб, Африкт гурил, гурилан бүтээгдэхүүний үнэ бол өсчихлөө шүү дээ. Яагаад гэвэл энэ хоёр дайн хийж байгаа хоёр орон чинь нийлээд 70-80 хувийг нь хангачхаж байгаа байхгүй юу, нийт улаан буудайны. Тэгээд нэг нь гараад явчихна гэхээр чинь наадах чинь бол нийт улаан буудайны 50 хувийг л нийлүүлдэг орон нь үлдээд л, бусад нь үндсэндээ нийлүүлэлтгүй болчхож байгаа юм. Бид нар харин одоо тариа тарьж байгаа, газар тариалангийн компаниуддаа хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл татаас өгч тариаг нь тариулахын оронд гаднаас о импорт гурил хийх ийм бодлого явуулж болохгүй шүү дээ. Энэ дээр би нэг хариулт авъя даа. Би ийм хоёр зүйл хэлсэн юм.

Ж.Ганбаатар: Эхлээд Жавхлан сайд хариулъя. Тэгээд Мэндсайхан сайд бэлдэж байя.

Б.Жавхлан: Даваасүрэн гишүүн өмнө нь бас ингэж хэлсэн. Энэ хууль маань өөрөө бол бас урт настай хууль биш байгаа юм. Энэ он дуустал гээд богино хугацаанд. Дэлхийн зах зээл дээрх нефтийн бүтээгдэхүүний үнэ бол шууд энэ дайны шокноос маш их савлагаатай байна. Энэ гал нь намжаад геополитикийн асуудал бага ч гэсэн энх тайвныхаа зам руу явах юм бол энэ буцаад буух болов уу гэсэн ийм олон улсын экспертүүдийн дүгнэлтийг л бид бас хараад л найдаад байгаа. Бид ямар шатахууны зах зээл дээр том тоглогч биш. Зүгээр л шууд импортлогч 100

writer.chimege.mn яриаг бичвэрт хөрвүүлэв.

хувь хамааралтай ийм улс. Тэгэхээр энэ богино хугацаанд бид шатахууны үнэд нь нөлөөлж чадахгүй юм чинь тэр шатахууныг эхний ээлжид ямар ч байсан нийлүүлэлтийнх нь нөөцийг нь одоо бид энэ дээр шок үүсгэхгүй 100 хувь авчих хэрэгтэй байгаа юм, төлбөрөө төлөөд.

Өндөр үнэтэй авдаг болчихсон юм чинь, урьд нь 10 доллароор арван литр авдаг байсан бол одоо 10 доллароор зургаа, долоон литр авахдаа хүрч байгаа учраас нөөцөө бүрдүүлэхийн тулд илүү их төлбөр төлөх хэрэгтэй болж ирж байгаа юм. Илүү их төлбөр төлнө, доллар унаа үнэтэй болоод байна. Яг биднээс шалтгаалж тэр савлагаануудыг нь багасгаж өгөх нэг юмны, цөөхөн хэдэн боломж хэрэгслүүдийнх нь нэг нь энэ ханшийн эрсдэлээс нь бууруулж өгөх л ийм боломж байгаа юм. Тэгэхээр он дуустал энэ хооронд шатахууны үнэ буцаад хэвэндээ ордоггүй юм гэхэд буух болов уу гэсэн бас хүлээлт байгаа. Тэгэхээр тэр хооронд бол ханшийнхаа нь энэ дарамтыг нь багасгаж өгье л гэсэн ийм зорилгоор оруулж ирж байгаа юм. Урт хугацаандаа бол Даваасүрэн гишүүнтэй бол санал нийлж байна. Энэ бол буцааж савлахад бас дийлэхгүй. Ирээдүйд ханш нь нэг жилийн дараа, хоёр жилийн дараа ямар байхыг одоо төсөөлөх боломжгүй байдаг учраас.

Ж.Ганбаатар: Мэндсайхан сайд үргэлжлүүлж хариулъя. Товчхон яриарай.

3.Мэндсайхан: Даваасүрэн гишүүний асуултад хариулъя. Засгийн газар энэ хаврын тариалалтыг нэмэгдүүлэх чиглэлээр газар тариалангийн компаниуддаа 3 үе хүүтэй, 100 тэрбум төгрөгийн хүнсний ногоо, тариалан эрхлэгчдээ 3 хувийн хүүтэй, 50 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг шийдээд гаргачихсан байгаа. Ингээд тариалан эрхлэгч талдаа бол дэмжлэгээ гаргачихсан юм. Гурил үйлдвэрлэгчид намрын ургац хураалтаас өнгөрсөн жилийнхээс ч харж байхад бид нарт гурилын үйлдвэр дээр эргэлтийн хөрөнгийн эх үүсвэрийг шийдэж өгөхгүй бол тариалалтаа нэмэгдүүлчихдэг, эргээд үйлдвэрүүд маань яг намрын богино хугацааны тариалалт сав, буулгахтай холбоотой асуудал дээр ч шахалт гардаг юм шиг байгаа юм. Ингээд үнэгүйдүүлэх асуудлыг гаргаж ирдэг ийм асуудлууд байгаа. Тэгэхээр гурилын үйлдвэрүүдээ бас эргэлтийн хөрөнгөөр дэмжье, боловсруулах үйлдвэрүүдээ гэдэг энэ бодлогын хүрээнд энэ зээлийг оруулж ирж байгаа. Импортоор будаа оруулж ирэх асуудлыг бол бид нар бүрэн хаачихсан байгаа. Энийг бид нар өөрсдөө зохицуулаад явах эрх нь манай яаманд байж байгаа, Хөдөө аж ахуйн сайдад.

Ж.Ганбаатар: Даваасүрэн гишүүн тодруулъя, 1 минут.

Ц.Даваасүрэн: Тэгвэл импортоор будаа оруулахыг нь бол би хаах юм байна гэж ойлгож байна шүү дээ. Тэгэхгүй бол наадах чинь импортын будаа болоод л нөгөө муу газар тариалан эрхлэх гэж байгаа хэдэн компанийнхаа будааг авахгүй, одоо байгаа будааг нь аваад нөөцлөөд, тэгээд тэр будаа зарсан мөнгөөрөө нөгөөдүүл нь уг нь шатахуунаа аваад ингээд газар тариалангийн эрхэлбэл зүгээр дээр байх гэж би бодож байна. Би зүгээр та нарын яг саяын хэлж байгаад бол нэг их итгэхгүй байна шүү. Яагаад гэвэл манай орон нутгийн компаниуд бол ийм л санал хэлж байгаа юм. Хэрвээ та нарын тэрэн шиг 100 тэрбум ингээд өгөх гэж байгаа байсан бол тэд нар надад ийм зүйл ярихгүй шүү дээ.

Хоёрт, шатахууны асуудал бол одоо ингээд наадах чинь их зовлонтой. 2023 оныг авсны дараа 2024 оны сонгууль гээд байж байгаа байхгүй юу. Тэгээд сонгуулийн өмнө ямар огцом гэнэт өсгөлтэй биш дээ. Энэ валютын ханш чинь хэд хүрэх юм бүү мэд шүү дээ. Одоо 3500, 3600 болчихсон байхад нь одоо энийгээ чөлөөлөх юм бол иргэд чинь бухимдаад л унана шүү дээ. Тэгэхээр ер нь ингээд нэг олсон хэдэн төгрөгөө бид нар шатаадаг л юм руу л яваад байна.

Ж.Ганбаатар: Асуулт байсан уу? Санал хэллээ. Даваасүрэн гишүүний саналыг сайн анзаарч тусгаж ажиллаарай гэж сайдуудад хэлье. Бямбацогт гишүүн асуулт асууя.

С.Бямбацогт: Би бас Даваасүрэн гишүүнтэй бас санал нэг байгаад байгаа юм. Нөөц яаж бүрдүүлэх вэ, энэ стратегийн бүтээгдэхүүний гурил, шатахуун. Махны асуудал харьцангуй гайгүй байх. Цаад талд нь будаа, төрөл бүрийн будаа, элсэн сахар, эмийн, эм, эмнэлгийн хэрэгсэл гэдэг асуудлуудыг бид онцгой анхаарах хэрэгтэй байгаа юм. Энэ төслөөс харж байхад бол ерөнхийдөө мах, гурилын нөөц бүрдүүлэх шатахууны компаниуддаа тодорхой хөнгөлөлттэй, хүү багатай зээл өгөх, валютын хувьд харьцангуй хямд ханшаар валютыг нийлүүлэх ийм л зохицуулалт. Шаардлагатай бол Засгийн газарт татварын хувь хэмжээг зохицуулах ийм эрх өгч байна. Үүгээр чинь юу шийдэгдэх гэхээр зээл аваад тэр зээлээрээ бараа бүтээгдэхүүн оруулж ирэх нь.

Гэтэл нөгөө талдаа яг энэ нөөцөө нэмэгдүүлэх тал дээр, өнөөдөр ороод ирчихсэн байгаа бараа бүтээгдэхүүнийг Засгийн газар улсын нөөцдөө худалдаж авах, тэр хэмжээгээр ард иргэд, аж ахуйн нэгжийн гар дээр байгаа, түгжигдээд байгаа тэр бараа бүтээгдэхүүн нь худалдаж аваад эргэлтийн хөрөнгийг нь суллаад өгчих юм бол тэр нөхдүүд маань эргээд тэр хөрөнгөөрөө нөөцөө бас дахиж хангамжаа нийлүүлэх ийм зохицуулалт хийж болохгүй юу? Тухайлах юм бол гурилын асуудал дээр. Сангийн сайдаас би асууж байгаа юм. Энэ чинь ерөнхийдөө бол зээл өгөх гээд байна. Зээл, хөнгөлөлттэй зээл өгөөд л асуудлыг, одоо та нарт хөнгөлөлттэй зээл өгчихсөн шүү, та нар бараа, бүтээгдэхүүний үнэ өсгөж болохгүй шүү, хангамжийг тасалж болохгүй шүү л гэдэг чинь аж ахуйн нэгжүүддээ ачаа үүрүүлэх гээд байна. Нөгөө талдаа тодорхой эх үүсвэр гаргаж аваад энэ бий болсон эх үүсвэрээрээ нөөцөө бүрдүүлчихье. Урьд нь улсын нөөц, стратегийн нөөцийн тухай хууль байж байгаа. Тэр хуульд байж байгаа нөөцийг юу гэдэг юм, хэмжээг хэд дахин нэмэгдүүлчихье. Тэр хэмжээгээр нөгөө талд нь Засгийн газар худалдаад авчихаар чинь нөгөө талд нь аж ахуйн нэгжийн чинь мөнгө суларна шүү дээ. Тэр суларсан мөнгөөрөө дахиад энэ татан авалтаа хийдэг ийм боломжийг бүрдүүлэх зохицуулалтыг энэ хуульд оруулж болохгүй юу?

Ялангуяа гурилын асуудал дээр, шатахууны асуудал дээр. Дахиад цаад талд нь бид нар энд орохгүй байж болно. Гэхдээ ямар нэгэн байдлаар зайлшгүй зохицуулах шаардлага байна. Стратегийн нөөцөд орчихсон төрөл бүрийн будаа, дээрээс нь элсэн сахар, эм, эмнэлгийн хэрэгсэл. Эдгээр дээр тодорхой хэмжээний бас нөөцийг бүрдүүлэх шаардлагатай байна. Энийг бас хэрхэн яаж зохицуулах бололцоотой юм бэ? Яг энэ хууль дээрээс бол зохицуулалт харагдахгүй байгаад байгаа юм. Тийм болохоор энийг оруулж өгмөөр байна. Ажлын хэсэг ч гэсэн энэ дээр ямар байр суурьтай байна, Булгантуяа гишүүн. Энэ байр сууриа илэрхийлээч. Шийдэл юу байгаа вэ, шийдлээ.

Ж.Ганбаатар: Сангийн сайд Жавхлан. Гишүүний асуултад хариулъя.

Б.Жавхлан: Бямбацогт гишүүний асуултад хариулъя. Бямбацогт гишүүн ээ, энэ чинь ерөөсөө яг л таны ярьж байгаагаар явж байгаа шүү дээ. Энэ гурав чинь бол гурвуулаа л яг ингээд арилжааны шугамаар, зах зээл нь өөрөө өөрийгөө нөөцлөөд явдаг ийм системтэй, тогтчихсон ийм байгаа юм. Энэ удаа ингээд ханшийн эрсдэл, ялангуяа шатахуун дээр бол нийлүүлэлтийн ийм бас эрсдэл үүсэж болзошгүй. Биднээс үл шалтгаалсан гадаад зах зээл дээрх энэ үнийн савлагаа иймэрхүү шокууд орж ирж байгаа учраас нөгөө уламжлалд явж ирсэн нөөцийн систем нь тасалдах эрсдэлтэй болоод байгаа юм. Энэ гацаанууд дээр нь одоо бид өөрсдөөс нь шалтгаалах юмнууд дээр нь л тусалж байгаа. Үнэ дээр нь, нөөцөө авах гэсэн чинь зээлийн эх үүсвэр нь

дутмаг байгаа бол нэмэлт зээл дээр нь Засгийн газар баталгаа гаргаж өгье гэж байгаа, ханшийнх нь эрсдэлийг нь бууруулж өгье гэж байгаа. Ийм зүйлүүд байгаа. Тэрнээс биш улс тэрийг худалдаж аваад нөөцлөөд энэ яваад ирсэн арилжааных нь бүтэн уламжлалт систем рүү нь орж эвдээд агуулахуудыг нь суллаж байгаад улс тэнд нь баахан нөөц аваачиж хийгээд бол хэрэггүй л дээ. Тэрийг бол бид нар буруу гэж үзсэн. Тэгэхээр уламжлалт, одоо манайх чинь улирлаар нь түрүүлж яваад л ингээд улирлаар нь явдаг шатахуун дээр бол тийм нөөцийн системтэй. Манай өөрсдийн дотоод шатахууны хадгалах нөөц боломж, агуулах сав нь ч яг тэр хэмжээгээрээ ингээд явж байдаг.

Махан дээр бол Мэндсайхан сайд түрүүн бас хэллээ, гурил, мах хоёр дээр. Махан дээр бол бид улсаас зохицуулдаг гол интервенц хийдэг махны нөөц. Энийг л сайн хангалттай бүрдүүлэх хэрэгтэй. Тэгээд зун долоон сар хүртэл ямар ч таслалгүйгээр хангалттай явуулах ийм систем. Мөн хойтонгийнхоо энэ системийг мөн одооноос ямар ч байсан хаа нэг газар гацаагүй байх тал дээр нь онцгой анхаарч ажиллах ёстой. Гурил дээр ч тэр. Тариаланчид, гурилын үйлдвэр, гурилын үйлдвэрээс авч эцсийн бүтээгдэхүүн гаргадаг гээд энэ явдаг бизнесийн бүтэн цикл дунд нь хаа нэг газар нь мөн тасалдал гарахгүй байх. Тэр нь тэгээд энэ чинь өөрөө жилийн хувьд ингээд бие биеэсээ хамааралтай тасралтгүй ингээд л явж байдаг. Гурилын үйлдвэрүүд нь тариаланчдаасаа будааг нь худалдаж аваад, тэд нар нь тэрүүгээрээ тариагаа тариад, тэгээд намар нь тэрийгээ өгөөд урьдчилгаа аваад, тэр дунд нь хаана нь ямар тасалдал гарах нь вэ, тэрэн дээр нь улсаас ороод зохицуулалт хийгээд ингээд тэр бүтэн циклийг нь тасалдуулахгүй явж байдаг ийм зарчмаар л явж байдаг байгаа.

Эм эмнэлгийн хэрэгсэл дээр бол гишүүд санал гаргаж байгаа. Одоо ямар ч байсан Засгийн газраас өргөн барьсан дээрээ бол бид энэ удаа эм эмнэлгийн хэрэгслүүд бол аль болох бизнесийнхээ зарчмаар арилжааны шугамаараа ингээд явах нь зүйтэй. Засгийн газар яг даах хэмжээгээрээ л даая гэж байгаа юм. Зохицуулж чадах юмнуудаа зохицуулъя л гэж байгаа юм. Монголбанк инфляцаа онил, Засгийн газар нийлүүлэлтээ онилъё. Өмнөх үнэ тогтворжуулах ч юм уу, өмнөх яг шокийн эсрэг авч хэрэгжүүлсэн, ажиллаж байсан арга хэмжээнүүд бол голдуу Төв банк бүх ачааллуудыг нь аваад ингээд явчхаж байсан. Энэ удаа бол Засгийн газар хамтарч ажиллана. Нийлүүлэлт тал дээр нь, зохион байгуулах тал дээр нь ингэж ажиллая гэж байгаа юм.

Ж.Ганбаатар: Тэр эм эмнэлгийн бүтээгдэхүүн чинь КОВИД-ын, юу билээ, их урт нэртэй хуулиар бас зохицуулагдсан байгаа биз дээ? Ер нь бол тэрэн дээр бас орон зайг нэлээн нөхчихсөн гэж ойлголт өгөөд байгаа шүү дээ. Мэндсайхан сайд гүйцээж хариулъя, 2 номерын микрофон, 2 минут өгье.

3.Мэндсайхан: Ерөнхийд нь Сангийн сайд хэлчихлээ дээ. Гол нь тэр нөөц бүрдүүлэх Бямбацогт гишүүний асууж байгаа асуулт бол тодорхой нэр төрлийн бүтээгдэхүүнүүд дээр засаг худалдаж аваад өөрөө нөөц бүрдүүлэх эх үүсвэр гаргана гэж байна даа. Тийм асуудал бол энэ хууль дээр бол тусгагдаагүй. Зүгээр, мах, гурил дээр, махан дээр бол бид нар мах бэлтгэх аж ахуйн нэгжүүд зээл олгож нөөц бүрдүүлэх, гурилын аж ахуй болон тариалан эрхлэлтийг дэмжих зорилгоор хөнгөлөлттэй зээлүүдийг гаргая, аж ахуйн нэгжүүд нь олгоод ажлуудаа хийгээд хэвийн үйл ажиллагааг нь хангая л гэдэг дээр энэ хуулийн зохицуулалт явж байгаа.

Ж.Ганбаатар: Бямбацогт гишүүн тодруулъя.

С.Бямбацогт: Тэгэхээр яг л ийм л байгаад байна л даа. Одоо энэ чинь 5.1.1. мах, гурилын нөөц бүрдүүлэх, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах зорилгоор мах бэлтгэн нийлүүлэгч, гурил үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүдийн writer.chimege.mn яриаг бичвэрт хөрвүүлэв.

эргэлтийн хөрөнгөд шаардлагатай хөнгөлөлттэй санхүүжилтийн банкаар дамжуулан олгоно гээд. Тэгэхээр гурил үйлдвэрлэгч компаниуддаа үндсэндээ хөнгөлөлттэй зээл олгоод, та нар гурилын үнэ барих ёстой шүү гэхчээ байгаа юм. Гурил үйлдвэрлэхийн тулд түүхий эд нь улаан буудай хэрэгтэй. Улаан буудай тарих байхад үрийн будаа хэрэгтэй. Энийг одоо хэрхэн яаж нөөцөө бүрдүүлэх юм, хэрхэн яаж тийм хангамжийг нь бий болгох юм, түүхий эдийг нь бэлтгэн нийлүүлэх, нөөцлөх юм гэдэг юм нь хаягдчихсан орхигдчихсон. Тэгэхээр газар тариалан эрхлэгч аж ахуйн нэгжүүддээ ямар дэмжлэг үзүүлж, нөөцийг нь бий болгох юм гэдэг юмнууд л хаягдчихаад л байх шиг байх юм л даа. Тийм болохоор л би Засгийн газар тодорхой эх үүсвэрээрээ нөөц бүрдүүлэх, гурилын нөөцөө бүрдүүлэх, улаан буудайн нөөцөө бүрдүүлэх, тэр эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцөө бүрдүүлэх, төрөл бүрийн будаа, элсэн сахарынхаа нөөцийг бүрдүүлэх.

Ж.Ганбаатар: Булгаа гишүүн хариулъя. Тодруулгад 1 минут.

Х.Булгантуяа: Энийг бас хэлэлцэх эсэх асуудал дээр чуулган дээр бас ярьж байсан. Ганцхан, хоёр, гуравхан төрлийн бүтээгдэхүүн биш бусад хүнсний бүтээгдэхүүнүүдийг, ногоо тариалалтыг дэмжих, эм эмнэлгийн хэрэгслүүдийг гээд сая Жавхлан сайд бас хариуллаа л даа. Энэ нь бол яах вэ, нэг бодлын Монгол Улсын Засгийн газар мэдээж бусад бүтээгдэхүүнүүд дээр ч гэсэн бараа бүтээгдэхүүний импорт, хил гаалиар оруулах гээд бүхий л талаар бид нар бол дэмжинэ. Гэхдээ энэ бол стратегийн гэж үзэж байгаа гурван төрлийн энэ бүтээгдэхүүн дээр бид нар Засгийн газрын зүгээс дааж чадах минимум ачаагаа энэ гэж үзэж байна. Бусад дээр нь бол бид нар ялангуяа хаврын тариалалт дээр, сая Мэндсайхан сайд бас хэллээ. Тариаланчдад бол 3 хувийн хүүтэй 100 тэрбумын зээл, ногоо, тариаланчдад 3 хувийн зээлтэй 50 тэрбумын зээл энэ хаврын тариалалтад зориулж гаргасан юм байна лээ. Одоо энэ хөтөлбөрөөр болохоор намар яг худалдан авалт дээр нь бид нар дэмжээд өгчихье. Мах нөөцлөх дээр, жишээлбэл махны компаниудад.

Ж.Ганбаатар: Оюунчимэг гишүүн асуулт асууя.

М.Оюунчимэг: Бүгдэд нь өглөөний мэнд хүргэе. Мэдээж дэлхийн нөхцөл байдлаас үүдээд энэ орж ирж байгаа арга хэмжээг нэн яаралтай бас авах нь зөв гэсэн байр суурин дээр бол байгаа. Харин яг ямар шугамаар, ямар зохион байгуулалттайгаар энийг хийх ёстой юм бэ гэдэг өөрөө бол маш чухал асуудал. Бид өмнөх 2018 онд Монголбанкна дээр Их Хурлын ажлын хэсэг гараад Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн шалгалт хийсэн л дээ. Тэгэхэд бол үнэхээрийн Үнэ тогтворжуулах хөтөлбөр нэрийн дор бараг л гурав дөрвөн их наяд төгрөг бол хийсээд гарсан. Тэр үед бид бензин шатахуун дээр тодорхой хэмжээгээр үнэ ханшийг нь яах вэ, барьсан л байх, нэг хэсэг хугацаанд. Тэгэхдээ энэ бол бас зорилгоо биелүүлж чадаагүй, ингээд улс орны хувьд бол нэлээд их хүнд байдалд, валютын нөөц энэ тэрийг байдалд оруулсан шүү дээ.

Энэ байдлыг давтагдуулахгүйн тулд өнөөдөр энийг яг хэнд энэ зээл, энэ үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд яаж гаргах юм бэ гэдэг өөрөө их чухал байна л даа. Одоо энэ дээр мах бэлтгэн нийлүүлэгчид, гурилын үйлдвэрүүд гээд тэгж байна. Өчигдөр Хүчит шонхор зах гээд л захуудаар яваад үзэхэд өнөөдөр малчдаас нийлүүлж байгаа мах өмнөх гурван сартай харьцуулахад 2000-4000 төгрөгөөр нэмэгдээд ороод ирсэн. Яагаад малчид үнээ нэмээд байгаа юм гэхээр нөгөө шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх үүднээс нөгөө мал эмнэлгийн гарал үүслийн бичигтэй махыг л оруулж ирж байгаа. Тэгээд бөөний үнээр бид нар авдаг, дээрээс нь түрээсийн лангуун дээр зарж байгаа учраас түрээсийн мөнгөө нэмдэг. Ингэж нэмэгдсээр байгаад махны үнэ өсөөд байгаа гэж байгаа юм.

Гэтэл уг нь Монгол Улс маань 66 сая малтай, 3-хан сая хүн амтай, хэдэн хувь нь мах их хэрэглэдэг вэ гээд л ингээд бодоод үзэхэд уг нь мах хамгийн хямд, хамгийн чанартай байх ёстой байтал бид өнөөдөр импортоор авч байгаа юм шиг түвшинд хүрчхээд ингээд сууж байгаа нь маш их харамсалтай байгаа л даа. Тэгэхээр Мэндсайхан сайд та энэ мах бэлтгэн нийлүүлэгч гэдэг дээр, энэ Үнэ тогтворжуулах хөтөлбөрт яг ямар хүмүүсийг хамруулах юм, малчдыг хамруулах юм уу, эсвэл бөөний үнээр авдаг ченжүүдийг хамруулах юм уу? Махны үйлдвэр гэдэг маань өөрөө бас хувийн, гэхдээ хэдхэн махны үйлдвэр байна шүү дээ, хоёр, гуравхан. Тэр махны үйлдвэрүүд маань бас ямар аваад яаж нэмж үнээ борлуулж зарж байна гэдэг бас асуудал байгаад байдаг. Бид нар тэрийг маш сайн мэднэ. Тэгэхээр энэ дээр яг зохицуулалт дээр та нар маань яаж бодлого барьж яаж ажиллах юм бэ? Хөрөнгө мөнгийг жишээ нь үнэ тогтворжуулах дээр яаж хувь хэмжээг нь тогтоох вэ? Яг үнэхээр үр дүнгээ хүрээд махны үнэ өсөхгүй, тодорхой хэмжээндээ бариад, дээрээс нь бас чанартай сайн махаа идэх бололцоог нь хангаж өгөх вэ? Энэ шат дамжлага дамжсан үнэ нэмэгдээд байгаа дээр нь, жишээлбэл түрээс дээр нь, энэ бөөний үнэ дээр нь зохицуулалт хийгээд, нийгмийн даатгалын шимтгэл гэдэг юм уу эсвэл бусад зүйлээр нь зохицуулалт хийх бололцоо жишээ нь байгаа юу? Энэ дээр нэгдүгээрт би хариулт авъя гэж бодож байна.

Хоёрт нь, мэдээж өнөөдөр ингээд НҮБ-аас гарсан дүгнэлтийг харж байхад дэлхийн хүнсний үнийн индекс 1990 оноос хойш түүхэн дээд түвшиндээ бол хүрсэн гэдэг нь бол үнэн байна. 2021 оны гурван сартай харьцуулахад индекс нь 33.6 хувиар, гурван сартай харьцуулахад бол 12.7 хувиар өсчихсөн байна л даа. Энэ бол дэлхийн хэмжээнд ингээд хүнсний бүтээгдэхүүний үнэ өсөж байгаа нь ойлгомжтой байгаа юм. Тэгэхээр бид нар түр зуурын нэг аргацаах арга хэмжээ болгоод авчихдаг. Гэтэл энэ маань дараа нь дахиад нэг өөр арга хэмжээнд авахад хүргэхгүйн тулд бид нар ямар зохицуулалт хийх вэ гэдэг өөрөө чухал байгаад байгаа. Тиймээс л би энэ дээр нь ингээд бодлогын арга хэмжээг их зөв аваасай, дараа нь нөгөө өмнөх Үнэ тогтворжуулах хөтөлбөр шиг ингээд мөнгө угаагдаад гарчхаад, дараа нь долларын ханш нь огцом хоёр дахин өсөөд, аж ахуйн нэгжүүд нь долларын ханшийн зөрүүний хохирол амсаад өнөөдөр зарим нь буруутан болоод ингээд явж байгаа шиг зүйлүүд дахин бүү давтагдаасай гэсэндээ энэ зүйлийг бол асууж байгаа юм биш үү.

Энэ дээр Монголбанкны оролцоо нь юу байх юм бол гэдгийг би бас нэгд нь асуучихъя. Хоёрт нь, энэ ийм буруу ойлголт яваад байх юм. Одоо орж ирж байгаа энэ хуулийн хүрээнд Монголбанкийг засгийн газартай хамтран ажиллах, Засгийн газрын эрх мэдлийн түвшинд орох гэсэн нэг мэдээллийг хэвлэл мэдээллээр яваад ийм байж болох уу? Энэ чинь Их Хурлын харьяа байгуулах гээд байх юм. Энд бас нэг хариулт авъя.

Ж.Ганбаатар: Хэн хариулах вэ? 2 номер, Мэндсайхан сайд гишүүний асуултад хариулъя.

3.Мэндсайхан: Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Махан дээр бол мах, гурил дээр авч байгаа. Энэ хуулийн хүрээнд авч байгаа арга хэмжээ нь валютын ханшдаа бол нөлөөлөөд байхгүй шүү дээ. Энэ бид нарын дотоод үйлдвэрлэл учраас. Зээл авч байгаа аж ахуйн нэгжүүд бол ханшийн эрсдэлд өртөнө гэсэн ойлголт бол байхгүй. Төгрөгөөрөө зээлээ аваад л махаа нөөцлөх асуудал явчихна. Махан дээр ингээд аваад үзэх юм бол энэ гурав, дөрөвхөн аж ахуйн нэгж байхгүй л дээ. Мах боловсруулах нийтдээ 150 орчим үйлдвэр байгаа. Энэ үйл ажиллагаа маань бас тийм шинэ ч яваад ирчихсэн юм биш. Тогтвортой яваад байгаа юм. Нийтдээ энэ жил гэхэд 23 аж ахуйн нэгж хөнгөлөлттэй зээл аваад Засгийн газраас өнгөрсөн 8 сард 100 тэрбум

төгрөгийн эх үүсвэр гаргасан, 3 хувийн хүүтэй түүгээр 23 аж ахуйн нэгж зээлээ арилжааны банк дээрээсээ аваад нийслэлийн хүн амын нөөцөд мах бэлдээд явж байгаа. Энэ хавар гэхэд бид нар нийтдээ 12.6 мянган тонн мах бэлдчихсэн байна. Энэ мах чинь өөрөө дээд тал нь 8900 төгрөгийн үнэтэй үхрийн мах, тэрнээс доод тал нь 7100 төгрөгийн үнэтэйгээр жижиглэнгийн худалдаагаар гараад энэ хаврын махны нөөцийн нийлүүлэлтээ бид нар хийгээд явж байгаа.

Мах бэлтгэл дээр орж ирэхэд бид нар мах хямд байх гэдэг ойлголтоосоо илүүтэй бид нар тогтвортой байлгах ёстой, нийлүүлэлтээ л нэмэгдүүлэх ёстой гэдэг дээр байгаад байгаа юм. Иргэд рүү энэ дээр бол зээлээ аваад орж болно. Гэхдээ энэ чинь эргүүлээд л банкн дээрээ төлөөд явж байх асуудал. Ямар нэгэн тийм аваад, энийг нэг их давуу тал болгоод байгаа асуудал бол байхгүй шүү дээ. Арилжааны банкн дээр бид нар эх үүсвэрийг нь шийдээд өгнө, зээлийн зөрүүг нь өгнө. Тэр аж ахуйн нэгж нөөцийн махандаа ороод хөдөө аж ахуйн яамтай гэрээгээ байгуулаад л явна. Гэрээний үүргээ биелүүлэхгүй бол бид нар хүүгийн зөрүү төлөх болон тэр компанийн зээлийн хөнгөлөлт дээр юу татаас, дэмжлэг үзүүлэхгүй л гэсэн санаагаар орж ирж байгаа.

Ж.Ганбаатар: Ажлын хэсгээс ажлын хэсгийн гишүүн Хүрэлбаатар гишүүн гишүүний асуултад хариулъя.

Ч.Хүрэлбаатар: Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Энэ Үнэ тогтворжуулах хөтөлбөрөөр Монголбанк мөнгө хэвлээд хэвлэх замаар энэ асуудлыг шийдэх гээд байгаа юм биш үү, Засгийн газар одоо яг энэ чиглэлээр Монголбанктай яг ийм ийм холбоосоор холбогдоод явчих юм биш биз дээ гэсэн ийм асуулт байгаа. Тэрийг бол зассан. Анх Засгийн газраас өргөн мэдүүлсэн хуулийн төсөл дээр бол Монголбанк арилжааны банкуудаар дамжуулаад аж ахуйн нэгжүүдэд мөнгө өгнө гэсэн агуулгатай зүйл байсан. Үүнийг нь өөрчлөөд банкны эх үүсвэрээр тэр банкнууд нь олгодог зээл олго, харин олгосон хүүгийн зөрүүг нь улсын төсөв дээрээ тавиад шийднэ гээд ингээд хэлчихээр эргэлтэд байгаа мөнгөний нийлүүлэлтийн хэмжээнд өөрчлөлт орохгүй. Эргэлтэд байгаа мөнгөний нийлүүлэлтийн хэмжээ нэмэгдчих юм бол энэ чинь өөрөө бүх бараа бүтээгдэхүүн үнийг дээш нь хөөргөдөг ийм аюултай, үр дүнгүй юм болдог шүү дээ.

2013 оноос 2016 оны хооронд явагдсан Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн гол алдаа нь энэ байсан байхгүй юу. Нийлүүлэлт нь хэвээрээ орж байгаа. Эргэлтийг нь мөнгөний нийлүүлэлтийн хэмжээг нь нэмээд байдаг, хэвлээд. Тэгэхээр юмны үнэ хөөрөгдсөөр байгаад ийм алдаа гарч байсан. Тэгэхээр саяын Засгийн газрын өргөн мэдүүлсэн зүйл дээр бид нар хоёр, гурван үг засах замаар энийг нь бол цэгцэлсэн.

Ж.Ганбаатар: Оюунчимэг гишүүн тодруулъя 1 минут.

М.Оюунчимэг: Сая Хүрэлбаатар даргын яриагаар, энэ засаад орж ирсэнд бол нь талархаж байна. Яагаад гэвэл ингэхгүй бол үнэхээр ноцтой юм байна лээ. Би өөрөө тэр шалгалтын ажлын хэсэгт ороод яг тэр 2013-2015 оны Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн алдаатай холбоотой асуудлууд дээр бид нар нэлээд ноцтой зөрчлүүд гаргаж ирсэн л дээ. Одоо Монголбанкных маань ч гэсэн энийг сайн мэдэж байгаа байх, тийм ээ? Та нар одоо яаж бэлтгэл хангаж байгаа вэ, энэ дээр? Жишээлбэл аж ахуйн нэгжүүд дээр ч, Монголбанкны зүгээс арилжааны банкуудтай хамтрах, энэ үнэ тохирч тогтворжуулах урт нэртэй хууль дээр Монголбанкны өөрсдийнх нь оролцоог яаж харж байгаа вэ? Энэ дээр надад нэг хариулт өгөөч.

Хоёрт нь, Мэндсайхан сайд аа, малчид яагаад махныхаа үнийг одоо ингээд нэмээд байгаа шалтгаан нь юу юм бэ? Мал ховордоогүй. Тэгэхээр энэ нөгөө мал эмнэлгийн гаргасан бичгийг маш сайн шахаж шаардаж оруулж ирж байгаа гэвэл энэ

бол маш зөв. Тэгэхээр энийгээ битгий бас тавьчихаарай. Тэгэхгүй бол бас эрүүл мэндийн асуудал, хүнсний аюулгүй байдлын асуудал өөрөө маш чухал байгаа учраас бид нар энэ дээр бол анхаарах хэрэгтэй л дээ. Яг үнэнийг хэлэхэд өнөөдөр Азийн орнуудаас хамгийн өндөр.

Ж.Ганбаатар: Лхагвасүрэн ерөнхийлөгч гишүүний асуултад хариулъя, 1 минут.

Б.Лхагвасүрэн: Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Өнөөдөр Төв банкны үнэт цаасан дээр 5 их наяд төгрөг байна. Төв банкны үнэт цаасан дээр байгаа энэ 5 их наяд төгрөг бол арилжааны банкны чөлөөт эх үүсвэр, зээлд гарах бүрэн боломжтой эх үүсвэр байгаа юм. Тэгэхээр энэ эх үүсвэрийг л буцааж эргэлтэд оруулах замаар л банк өөрөө энэ эх үүсвэрээ цаашаа зээл болгож гаргаж авна. Тэгээд хүүн дээр нь татаас хэлбэрээр хүүний хөнгөлөлт үзүүлэх учраас энэ зээл маань одоо ингээд чөлөөтэй гарах боломжтой. Өмнөх тэр 3 хувийн хүүтэй зээлийн хөтөлбөр эд нартай яг төстэй хэлбэрээр явах боломжтой. Монголбанкны зүгээс хамгийн гол нь энэ ханштай холбоотой хэсэг байгаа, нефтийн бүтээгдэхүүний. Энэ дээр бол угаасаа санхүүгийн үүсмэл хэрэгсэл гэж байдаг. Форвард, своп хэлцэл хийж явдаг. Тэгэхээр банк бол тодорхой түвшинд харилцагчийнхаа ханшийн эрсдэлээс хамгаалах үүднээсээ энэ энэ журмын энэ хэрэгслийг ашиглах боломжтой. Банк нь Монголбанктай бас ийм хэмжээний хэлцэл хийх, оролцох боломжтой.

Ж.Ганбаатар: Мэндсайхан сайд гишүүний асуултад хариулъя, 1 минут.

3.Мэндсайхан: Малчдын хувьд бол мал мах хэрэгцээлэх шаардлага нь өөрөө нийлүүлэлт бага байна л гэж харагдаж байна л даа. Өнгөрсөн жил бид нар малчдад зориулсан 200 тэрбум төгрөгийн 3 хувийн хүүтэй эх үүсвэр гаргасан юм. Энэ нь өөрөө ХААН банкан дээр тодорхой хэмжээний малчдын маань өр өмнө үүссэн зээлийг нэг удаа ингээд хугацааг нь сунгаад шинэчлээд өгчихсөн. Тэгэхээр эргээд малчид маань эдийн засгийн хувьд бол бас мал, мах хэрэгцээлэх шаардлага нь бас бага байна л гэж харагдаж байгаа. Түүнээс биш малчид маань үнээ нэмье гэсэн ийм бодлогын тийм хүн биш шүү дээ. Малчид өөрсдөө л хэрэгцээгээ үндэслээд л гаргаж байгаа. Мэдээж энэ нийлүүлэлтийн зах зээлээс наашаа малчны хотноос ирэх хооронд нэмэгдэж байгаа тээвэр болон боловсруулах, Улаанбаатар хот чинь дандаа технологийн дагуу бэлтгэсэн, эрүүл ахуйн шаардлага хангасан байх оруулж ирж байгаа. Энэ нь өөрөө үйлдвэрт бэлтгэх гэж байгаа ийм нэгжийн зардал шингээд л зах зээл дээр гарч ирж байгаа ийм л асуудал байгаа л даа. Одоо бид нар нөөцийн махыг өнгөрсөн намар.

Ж.Ганбаатар: Дараагийн асуултад хариулахдаа гүйцээгээд хариулаарай. Чинзориг гишүүн асуулт асууя.

С.Чинзориг: Хэдэн зүйл тодруулъя. Нэг дэх асуудал нь мөнгөний бодлого батлахдаа Их Хурал, Засгийн газарт ер нь ийм байдал руу явах нь гэдгийг бас Их Хурал яриад мөнгөний бодлого батлахдаа тодорхой бас тогтоолд нь заалт оруулж өгсөн шүү дээ. Бараа, бүтээгдэхүүний хомстол үүсэхгүй байх, үнийн өсөлт гаргахгүй байх чиглэлээр хөтөлбөр боловсруулж хэрэгжүүл, энэнд нь Монголбанк дэмжлэг үзүүлж ажил үзүүлж ажилла гэсэн ийм Их Хурлын шийдвэр гарсан. Тэгэхээр энэ үнийн бараа бүтээгдэхүүн хомстолтой холбоотой үнийн өсөлттэй холбоотой асуудлыг одоо ярьж байгаа асуудал биш шүү дээ. 2022 оны мөнгөний бодлого батлахдаа Их Хурал шийдвэр бол гаргачихсан. Энэ хүрээнд Засгийн газар, Монголбанкнаас ямар арга хэмжээ авсан юм бэ гэдгийг Сангийн яам, Монголбанк тодорхой нэг хэлээч. Хоёр дахь асуудал нь, одоогийн оруулж ирж байгаа энэ хууль чинь Мэндсайхан сайд аа, нөөц бүрдүүлэхтэй холбоотой хууль юм уу, үнийн өсөлтийг бас тогтворжуулах, хязгаарлахтай холбоотой хууль юм уу гэдгийг нэлээн тодорхой хэлж өгөөч.

Хоёрдугаарт энэ асуудал чинь хууль батлагдсанаар энэ оны махны нийлүүлэлт, гурилын нийлүүлэлтэд үйлчлэх гээд байгаа юм уу? Ирэх оны махны нийлүүлэлт, гурилын нийлүүлэлтэд нөөц бүрдүүлэхтэй холбоотой асуудал дээр дэмжлэг үзүүлэх гэж байгаа юм уу гэдгийг нь л бас нэг тодорхой хэлж өгөөч?

Гурав дахь асуудал нь, махны үйлдвэрүүдэд, гурилын үйлдвэрүүдэд хөнгөлөлттэй зээл өгнө, хүүгийн зөрөөг нь татаас өгнө гээд ингээд хуулийн төсөл орж ирж байгаа юм. Би бол нэг зүйл дээр эргэлзээд байгаа юм. Яг үндсэн үйлдвэрлэгчдээ дэмжихгүй бол хэчнээн махны үйлдвэрүүд, гурилын үйлдвэрүүдэд хөнгөлөлттэй зээл өгөөд нөгөө тариалан тариалангийн үйлдвэр чинь явахгүй бол, нөгөө махны үйлдвэр чинь явахгүй бол, малчин махаа бэлдэхгүй бол, тариаланчид чинь тариалангаа тарихгүй бол энэ ажил чинь тэгээд бодитой үр дүнд хүрэх үү, үгүй гэж би бол эргэлзээтэй байгаа юм. Тэгэхээр яг тариаланчдаа, малчдаа яаж одоо дэмжих гэж байгаа юм бэ? Тэр үндсэн үйлдвэрлэлийн дэмжиж байж энэ гурил будаатай байх, махтай байх асуудлаа бас бодохгүй юм уу гэсэн, би нэг бодоод байгаа юм.

Дараагийн дөрөв дэх асуудал нь, яах вэ, шатахуун дээр бол болох байх гэж бодоод байгаа юм. Мах, гурил хоёр дээр чинь манайд бэлтгэн нийлүүлэлтийн нэгдсэн систем, тогтолцоо байхгүй. Нөөц бол бүрдэнэ байх. Гэхдээ нөгөө бэлтгэл нийлүүлэлтийн систем байхгүй учраас үнийн өсөлт бас гарах хөөрөгдөл гаргах ийм асуудал байна гарна аа. Энийг та бүхэн маань яаж зохицуулна гэж харж байгаа юм бэ? Дундаас нь нөгөө үйлдвэрүүд үнээ нэмэх, нөгөө гурилын ченжүүд, махны ченжүүд нь үнийг нь нэмэх, ингээд наад энэ арга хэмжээ чинь байгаа онохгүй, хэрэглэгчдээрээ бас нөгөө гурил, махны чинь үнэ нэмэгдэж очоод ингээд иргэдийг бас бухимдуулах ийм бас арга хэмжээ болчих вий дээ гэж би жоохон болгоомжлоод байгаа юм. Энэ дээр та бүхэн юу гэж бол харж байна. Энийг хаах яах вэ, тэр нэг гэрээ байгуулна гээд байгаа. Үйлдвэртэй байгуулна. Тэгээд гурилын үйлдвэрүүд чинь хаан мэдэж байгаа, жижиглэн худалдаа эрхэлдэггүй шүү дээ, өөрсдөө. Ингээд хэрэглэгч дээр оччихоод жижиглэнгийн үнэ нэмэгдэх ийм нөхцөл бололцоо үүсчих вий дээ гэдгийг бас та бүхэн маань яаж харж байгаа юм бэ?

Махтай холбоотой асуудал нь зөвхөн Улаанбаатар хотын иргэдийн хүнсний хэрэгцээ шаардлагатай махны хүрэлцээг хангах, нэмэгдүүлэх асуудал яриад байгаа юм уу? Аймгуудын төвүүд, төв суурин газруудын иргэдийн махны хэрэгцээ, нөөцтэй холбоотой асуудал ярьж байгаа юм уу? Ер нь бол махны асуудал ярихаар бид нар зөвхөн Улаанбаатар хотын махны хэрэгцээ гээд яриад байдаг. Төв, суурин газрууд аймгийн төвүүдийн махны хэрэгцээтэй холбоотой асуудлыг ер нь яагаад энэ яам ярьдаггүй юм бэ? Энэ дээр бас анхаарлаа хандуул. Энэ хууль батлагдсаны.

Ж.Ганбаатар: Гишүүний асуултад хариулъя. 2
номер, Мэндсайхан сайд. Лхагвасүрэн ерөнхийлөгч бэлдэж байгаарай.

3.Мэндсайхан: Чинзориг гишүүний асуултад хариулъя. Үйлдвэрлэгч талдаа, ялангуяа үр тарианы үйлдвэрлэгчдэд Засгийн газар 3 хувийн хөнгөлөлттэй зээл, 100 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг Монголбанктай хамтраад арилжааны банкаар дамжуулаад гаргаж байгаа. Хүнсний ногоо үйлдвэрлэгчдээ 50 тэрбум төгрөг гээд нийтдээ газар тариалан, хүнсний ногоо эрхлэгчдэд 150 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг гаргачхаж байгаа юм. Үйлдвэрлэгч талдаа бид нар боловсруулах үйлдвэрүүдээ гурилын үйлдвэр, мах боловсруулах үйлдвэрүүдээ энэ зээлийг өгснөөрөө худалдан авалтыг дэмжиж, нөөцийг бүрдүүлэх, нийлүүлэлтийг нэмэгдүүлэх л бодлого баримталж байгаа. Нийлүүлэлт бид нар хангамж талдаа л нийлүүлэлтийн шок үүсэхгүй байх юм бол үнэ тогтвортой байна гэж үзэж байгаа. Хэрэглээний үнийн сагсанд хамгийн их нөлөөлж байгаа хоёр бүтээгдэхүүний энэ

гурил, мах хоёр нийлээд 21-22 хувийн инфляцид үзүүлж байгаа нөлөөлөл нь өндөр байгаа. Энэ үнийг л тогтвортой байлгахын тулд нийлүүлэлтийг дэмжих бодлого гэж энэ хууль дээр энэ хоёр бүтээгдэхүүнийг сонгож оруулж ирсэн.

Төв,суурин газрын хувьд бол бид нар нөөцийн махаа бол Улаанбаатар хотод бүрдүүлээд явж байна. Өнөөдрийн Засаг захиргааны нэгжийнхээ тухай хуулиараа төв, суурин газрын нөөцийг тухайн аймгийн Засаг даргын Тамгын газар нь өөрөө бэлддэг л ийм зохицуулалттай байгаа л даа. Тэгэхдээ энэ хууль дээр бид нар аж ахуйн нэгжүүдийг оролцох эрхийг нь бол хязгаарлахгүй. Мах боловсруулах үйлдвэрүүд маань энэ зээлд хамрагдаад төв, суурин газар зах зээлийн өрөө сонгоод л нөөцөө бүрдүүлээд явах боломж нь байгаа.

Ж.Ганбаатар: Ажлын хэсгийн 3 номер, Лхагвасүрэн ерөнхийлөгч.

Б.Лхагвасүрэн: Чинзориг гишүүний асуултад хариулъя. Өнгөрсөн онд төрийн мөнгөний бодлогын үндсэн чиглэлийг батлах явцад бол инфляцыг тогтворжуулах, тэгээд тэрэн дээрээ Монголбанк, Засгийн газар хоёр хамтарч ажиллахаар тусгайлан тогтоол дээр заалт орсон байгаа. Ялангуяа нефтийн бүтээгдэхүүний хомстлоос сэргийлэх үүднээсээ Засгийн газрын 311 дүгээр тогтоол гарсан. 28 аж ахуйн нэгжид гэрээ байгуулж 45 хоногийн ийм нөөц бүрдүүлэхээр ийм заалттай тогтоол байгаа. Энэ хүрээнд нь Монголбанкнаас бол репо санхүүжилт дээр бол ингээд тодорхой хөнгөлөлттэй зээл өгөөд явж ирсэн. Гэсэн хэдий ч ингээд сая шинээр үүссэн нөхцөл байдал буюу олон улсын геополитикийн асуудалтай холбогдуулаад нөөцөө яг бүрдүүлж чадах уу, энэ нөөцөө бүрдүүлэхээс гадна үнэд нь томоохон өөрчлөлт бараг 20, 30 хувийн ийм үнийн өсөлт гарсан учраас бол тогтвортой нефтийн бүтээгдэхүүнийг тогтвортой байлгах үүднээс арай илүү их нөөц барих, үнийг нь илүү их өсгөхгүй байх үүднээсээ бас бусад хөнгөлөлт, тодорхой дэмжлэгүүдийг үзүүлэхээр энэ төсөл маань орж ирж байгаа. Тэгэхээр оны эхнээс хойш явж байсан репо санхүүжилт маань ингээд хэвээрээ үргэлжлээд явж байгаа учраас бол өнөөдрийг хүртэл бол нефтийн бүтээгдэхүүн үнэ тогтвортой байгаа, тодорхой хэмжээний нөөц бүрдчихсэн байгаа нь бол энэ Засгийн газар, Монголбанк хоёрын тал авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүн л гэж харж байгаа юм.

Ж.Ганбаатар: Чинзориг гишүүн тодруулъя.

С.Чинзориг: Мөнгөний бодлого баталсан Их Хурлын шийдвэрт чинь ер нь нь ийм нөхцөл байдал бий болох нь гэдгийг бас хараад бараа бүтээгдэхүүний хомстол үүсгэхгүй байх үнийн өсөлт бас гаргахгүй байх чиглэлээр хөтөлбөр боловсруулж хэрэгжүүл гээд Их Хурал шийдвэрээ гаргачихсан шүү дээ. Тэгэхээр манай Засгийн газар яг энэ чиглэлээр юу хийсэн юм бэ? Яг тодорхой тийм хөтөлбөр гарсан юм уу, үгүй юм уу гэдгээ нэг тодорхой хэлээч.

Хоёр дахь асуудал, орон нутгийн төв, суурин газар, ялангуяа аймгийн төвүүдийн махны хэрэгцээтэй холбоотой асуудал дээр бас Засгийн газар, Хөдөө аж ахуйн яам бас жаахан дэмжлэг өгч ажиллаж баймаар байгаа юм. Одоо ингээд махны үйлдвэрүүдэд хөнгөлөлттэй нөхцөлтэй зээл өгөх юм бол аймгууд ажиллаж байгаа махны үйлдвэрүүдийг хөнгөлөлттэй зээлд хамруулах, төв, суурин газар, аймгийн төвүүдийн иргэдийнхээ хэрэгцээний махыг бас нөөцлөх энэ асуудал дээр дэмжлэг үзүүлэхгүй бол, тэгээд орон нутаг өөрийн мэд гээд хаячихдаг, тэгээд зөвхөн Улаанбаатар хотын л махны хэрэгцээний л юм яриад байдаг. Бас ингэж болохгүй ээ. Энийг бас анхаарах хэрэгтэй.

Ж.Ганбаатар: Жавхлан сайд.

Б.Жавхлан: Өнгөрсөн онд энэ оны мөнгөний бодлогын үндсэн чиглэлийг ярьж байхад Чинзориг гишүүн яг ингэж хэлж байсан шүү. Одоо эргээд харахад өнөөдрийн энэ үүссэн нөхцөл байдал, энэ дайн тулааныг ер нь олж харж байсан юм шиг байгаа юм аа. Тэрийгээ бид нарт маш тодорхой бас хэлээгүй, нэг л нууцлаг яриад байсан. Тэгээд одоо бид чадлаараа л ажиллаж байна л даа. Тэгээд л одоо энэ хуулийг оруулж ирж байгаа юм. Хөтөлбөр бол үүссэн нөхцөл байдалтай уялдуулаад харьцуулахад бол сулдах гээд байгаа юм. Тийм учраас хууль оруулж ирээд, Монголбанк нь инфляц талаасаа, Засгийн газар нь нийлүүлэлт талаасаа ингээд бодлогоо уялдуулаад, хувийн хэвшил, тэр дундаа тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, компаниуд нийгмийн хариуцлага талаасаа оролцоогоо хангаад, хуулийн хүрээнд алдаа мадаггүй ингээд явъя. Гэхдээ бас даах чадахаараа.

Ж.Ганбаатар: Дараа нь гүйцээд хариулчихаарай, сайд. Баттөмөр гишүүн асуулт асууя.

Б.Баттөмөр: Гол нэрийн бараанууд дээр төрийн зохицуулалтууд зохицуулалт хийхээр оруулж ирж байгаа юм байна. Энийг бол дэмжиж байна л даа. Тэгэхдээ ардчилал, зах зээлийн нийгэмд шилжсэн энэ 30 жилийн хугацаанд махаа шийдэж чадаагүй, гурилаа шийдэж чадаагүй, нефть бүтээгдэхүүний асуудлыг шийдэж чадаагүй байгаа нь бол үнэхээр харамсалтай байна л даа. Монгол Улс чинь 66 сая толгой малтай гэж байгаа шүү дээ. Тэгээд банкнаас мөнгө гаргаж, төрөөс мөнгө гаргаж энийг зохицуулж байна гэдэг бол үнэхээр харамсалтай л байна л даа.

Ер нь Монгол Улсад хэтийн бодлого, төлөвлөлт гэж байна уу, үгүй юу? Яаж энэ бахаа хангах юм бэ? Яаж энэ ард иргэдийг махаар хангаж байх юм бэ? Энэ зах зээлийнхээ зарчимд хэзээ орох вэ. Мэндсайхан сайд? Энийг хэрэв хариулж, хэлж өгөөч.

Хоёрдугаарт, энд би буруу хараад байна уу? 5.1.3 дээр санхүүгийн үүсмэл хэрэгсэл ашиглана, энэ хуулийн 3.2-т заасан бараа бүтээгдэхүүний импортын төлбөрийн гадаад валютын ханшийн эрсдэлийг бууруулах гэж байгаа юм. 3.2-т нь газрын тосны бүтээгдэхүүн гурил, мах гэж байгаа юм. Тэгээд энэ гурил махаа бас гаднаас авах гэж валют зарцуулах гээд байгаа юм уу, хаашаа юм? Энд нэг асуултад хариулж өгөөч.

Монгол Улсын далд эдийн засгийн хэмжээ, Ерөнхий сайд ч хэлээд байгаа. Энэ тээвэр ложистик дээр, тэрийгээ бид далд эдийн засгаа бууруулж чадах юм бол Монгол Улсын төсвийн орлого, эдийн засаг нэг дахин өснө гэсэн ийм тооцоо хийж ярьж байгаа. Тэгэхээр энэ далд эдийн засгийг чинь өөгшүүлж, далд эдийн засгийг л нөхцөлдүүлж байдаг энэ салбар чинь алтны салбар шүү дээ. Ялангуяа жижиг алтны үйлдвэрүүд, алтны уурхайнууд. Эзэд нь маш тансаг амьдардаг. Дэлхийн хэмжээний маш үнэтэй зүйлийг авч хэрэглэдэг. Улсад татвар төлдөггүй. Тэгээд энэ дээр ингээд өршөөнө, урьд нь тушаагаагүй бол өршөөнө гээд ингээд энэ өөгшүүлээд байх юм уу, яах юм? Энэ чинь ард түмний одоо мэдэлд байдаг л баялаг шүү дээ. Энэ алт газрын доорх элемент. Тэгээд энийг тушаадаггүй, банкнаас мөнгө гаргаж тусалдаг. Худалдаж авах нь Лондонгийн металлын бирж үнээс 5 хувиар нэмэгдүүлж авдаг. Энэ алтны салбарыг одоо яах юм бэ? Цаашдаа ингээд энэ далд эдийн засгийг нь, хил давуулдаг барьдаг энэ юмнуудыг нь яая гэж бодож байгаа юм бэ? Тооцоо байна уу, үгүй юу? Хэчнээн хэмжээний алт хил даваад байна? Энийг тооцсон тооцоо байна уу, үгүй юу гэж хоёр дахь асуудал энэ.

Гурав дахь нь бол, юу вэ гэхээр энэ газрын тосны бүтээгдэхүүн Тамсагаас нефть боловсруулах үйлдвэр лүү хоолой татна гэж байгаа юм. Энэ хоолой татах ажил ямархуу явцтай явж байна? Ёндон сайдаас асууж байна. writer.chimege.mn яриаг бичвэрт хөрвүүлэв.

Тендер нь зарлагдсан уу, үгүй юу. Ямар хэмжээний өртгөөр босгох гэж байгаа юм. Энийг татах нь зүйтэй юм уу, эсвэл тэр урагшаагаа гаргах нь зүйтэй юм уу? Урагшаагаа гаргаад тэр үнээрээ хойд талаасаа нефть бүтээгдэхүүн, хойд урдаасаа нефть бүтээгдэхүүн төмөр замаар авах нь илүү ашигтай байна уу, үгүй юу? Энэ тооцоонууд ер нь яаж хийгдэж байна? Нефть бүтээгдэхүүний хятадын талтай хийсэн Петрочайнатай хийсэн гэрээгээр 23 хувийг нь авна гэж байгаа юм, Монгол улс. Бид монголчууд чинь бол дотооддоо импортоор биш дотооддоо нефтийн үйлдвэртэй болно гээд л хөөрцөглөөд байдаг. Ялгаа байхгүй бол тэр 70-н хэдэн хувийг нь өөрсдийнхөө хэрэгцээт нефть бүтээгдэхүүний ихэнх хувийг, 70-н хэдэн хувийг нь импортоор бас валют зарцуулж авна шүү дээ. Тэгэхээр Монгол Улсын нөөцийн ногдох хэмжээг нэмэгдүүлэх чиглэлээр ямар ажлууд хийгдэж байна? Ийм асуултуудад хариулт авъя.

Ж.Ганбаатар: Эхлээд Булгантуяа гишүүн гишүүний асуултад хариулъя. Дараа нь ажлын хэсэг бэлдэж байгаарай.

Х.Булгантуяа: Баттөмөр гишүүний асуултад хариулъя. Яг тэгж уншигдаад байгаа юм, 5.1.3 нь Баттөмөр гишүүн ээ. Тэгээд ажлын хэсэг дээр бид нар үүнийг зассан. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл ашиглан энэ хуулийн 3.2-т гэхээр түрүүн Даваасүрэн гишүүний бас хэлээд байгаа нь ч бас үнэн. Эндээс чинь гурил махыг гадаадаас худалдаж авах гэж байгаа юм шиг сонсогдоод байна, энэ чинь эсрэгээрээ дотоодын үйлдвэрлэгчдээ дэмжих гэдэг утгаар орж байгаа биз дээ гэж. Тэгээд үүнийг бид нар ажлын хэсэг дээр өөрчлөөд 3.2 биш 3.2.1-д гээд газрын тосны бүтээгдэхүүн. Энэ бол гадаадаас гадаад валютаар авах гэж байгаа учраас энэ ханшийн эрсдэлээс сэргийлэх, санхүүгийн үүсмэл хэрэгсэл ашиглах байдлаар. Харин өнөөдөр арилжааны банкнууд дундаас нь ханшаас нь арилжаа хийж ашиг олох байдлыг нь бол хориглох гэдэг байдлаар бид нар өөрчлөн найруулсан байж байгаа юм. Газрын тостой асуудлыг сайд хариулчих байх.

Ж.Ганбаатар: Эхлээд Ёндон сайд хариулъя. Ажлын хэсгийн 1 номер өгье.

Г.Ёндон: Баттөмөр гишүүний асуултад хариулъя. Дамжуулах хоолойгоор Тосонгийн талбайгаас Алтан ширээгийн үйлдвэр хүртэл 530 километр нефть дамжуулах хоолой барих энэ төслийг тендерийг 2021 оны 3 сард зарлаад, үүнээс хойш таван удаа хугацаа сунгаад хамгийн сүүлд 2021 оны 12 сард тендерт ялагчийг тодруулсан байж байгаа. Тендерт дөрвөн компани санал ирүүлсэн. Хятадын хоёр компани, Энэтхэгийн нэг компани, Японы нэг компани санал ирүүлсэн. Ингээд ер нь бол Японы компанийн санал зөвхөн техникийн саналтай үнийн саналгүй ирсэн. Нөгөө гурван санал дотроос техникийн санал шаардлага, хангасан үнээр харьцуулж үзэхэд бол Хятадын Норинко компанийн санал бол хамгийн хямдхан, нөгөө хоёр нь бол 620 орчим сая доллар байсан.

Ер нь бол Энэтхэгийн EIL компанийн хийсэн техник, эдийн засгийн үндэслэлээр бол үнэ нь бол 600-620 сая доллароор хийх ёстой байсан. Тэгээд эдгээр саналууд бүгд 620 сая доллар ирсэн. Норинко компанийн санал бол 388-397 сая доллар. Энэ диаметрээсээ хамаарсан. Гэхдээ нэг онцлог нь болохоор бол Засгийн газрын баталгаа нэхэхгүй, зээлийн хүүгүй, нүүрс урьдчилан одоо нүүрс нийлүүлэх нүүрсээ төлбөрийг авах боломжтой гэсэн санал ирсэн учраас энэ компанийг шалгаруулаад тодруулаад гэрээ хийх ажил одоо хэлэлцээ хийж байгаа. Ер нь бол 1 сарын сарын эхээр бол Нятадын талаас яг гэрээ хэлцэл хийх хүмүүс ирсэн байж байгаа. Эдгээр хүмүүстэй бол гэрээ хэлцэл хийгээд үндсэндээ дууссан. Ирэх долоо хоног Засгийн газрын хуралдаан дээрээ танилцуулаад ингээд гэрээ хийх ажил явагдана. Тэгэхээр дамжуулах хоолой

бол гүйцэтгэгчтэй болсон, шалгарсан, одоо энэ ажил бол хийгдэж байгаа. Та бас сая энэ бид нар Петрочайна дачин тамсаг компанийг.

Ж.Ганбаатар: Ёндон сайдын микрофоныг 2 минутаар сунгая.

Г.Ёндон: Би товчхон хариулъя. Петрочайна дачин тамсаг компанитай хийж байгаа бүтээгдэхүүн угаах гэрээ бол Тосон тамсаг талбайнуудтай байдаг. Мөн Тосонгийн талбай бол хамгийн анх байгуулсан Америкийн Соко интернэйшнл компаниас одоо яг хүлээж, энэ бол хувьцаа худалдан авах байдлаар шилжүүлж авсан гэрээ байдаг. Энэ гэрээгээр болохоор бол Монгол Улсын тал бол 24 хувийг, өртөг нөхсөний дараа 24 хувийг авдаг. Тамсаг дээр болохоор энэ хувь арай жаахан илүү. Яагаад гэвэл Тамсагийн талбай дээр роялти авдаг. Хамгийн анх Тосонгийн талбай дээр гэрээ байгуулахдаа тухайн үед Монгол Улс газрын тостой тосгүйгээр мэдэхгүй, ер нь бол энэ тал дээр манайх бол геологи хайгуулын ажил, газрын тосны чиглэлээр хориод жил тасалдчихсан иймэрхүү нөхцөл байдал тухайн үед гэрээ байгуулахдаа бол роялти буюу газрын тосны нөөц ашигласны төлбөр нь Монголын талын ашигт тосны үнэ дотор орно гэсэн ийм гэрээнд дотор тусгагдсан заалттай байдаг. Энүүгээрээ явж байгаа.

Манайх газрын тосноос бол жилд ойролцоогоор эдгээр 24 хоёр хувьтай харьцуулсан байдлаар жилд бол 200 орчим тэрбум төгрөгийг төвлөрүүлдэг. Энэ нь бол одоогийн байдлаар 100 сая доллар бол арай хүрэхгүй. Монгол Улс бол газрын тосны бүтээгдэхүүнийг жилдээ авч байгаа үнэ нь болохоороо л 1 тэрбум орчим америк доллар байдаг. 2020 онд бол КОВИД-ын жил 800-н хэдэн сая доллар болсон. Ер нь бол жил болгон Монгол Улсын газрын тосны хэрэглээ бол 7-10 хувиар өсдөг. Газрын тос боловсруулах үйлдвэр 2025 онд ашиглалтад орно гэж төлөвлөж байгаа өнөөгийн нөхцөл байдалд бол Монгол газрын тос боловсруулах үйлдвэр 1.5 сая түүхий тосыг боловсруулж 1.3 сая тонн бүтээгдэхүүн гаргана гэж бодоход нийт хэрэглээний бол 55-60 хувийг л хангахаар байж байгаа. Баярлалаа.

Ж.Ганбаатар: Мэндсайхан сайд гүйцээж хариулъя. 2 минут, Мэндсайхан сайд.

3.Мэндсайхан: Баттөмөр гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр Засгийн газар ямар нэгэн мах, гурил дээр үнэ тогтоогоод байгаа асуудал огт байхгүй шүү дээ. Бид нар мах, гурилын нийлүүлэлтийг нэмэгдүүлэх замаар үнийг тогтвортой барья л гэдэг бодлого хэрэгжүүлж энэ хууль дээр энэ зах зээлд оролцогч нар зээлийн хөнгөлөлттэй дэмжлэг үзүүлье гэдэг ийм шийдвэр гаргаж байгаа. Түүнээс биш одоо махны үнэ төд, гурилын төд байна гэдэг ийм чөлөөт зах зээлийн үнэ тогтоох зарчим руу Засгийн газар ороод байгаа асуудал байхгүй.

Ж.Ганбаатар: Баттөмөр гишүүн тодруулъя.

Б.Баттөмөр: За, яах вэ, Засгийн газар орж байна ч гэж хэлээгүй л дээ, Мэнхсайхан сайд аа. 66 сая толгой малтай, тэгээд төрөөс мөнгө гаргаж энэ зохицуулж байгаа хэлбэр маань одоо 30 жил явчихлаа. Зөв үү, буруу юу л гэдэг л асуудал танаас асууж байгаа юм л даа. Би бол буруу гэж ойлгож байгаа. Энэ зах зээлийнхээ зарчмаар л явах ёстой. Махан дээр, гурил дээр, энийг асуусан юм.

Хоёрдугаарт нь, Ёндон сайдаас асуухад манай энэ газрын д тосны чанар юу вэ? Хоолойгоор татахад нийцэх үү, ямар вэ? Эдийн засгийн үр ашиг нь импортоор түүхий тосоо урагшаа гаргаад, хойноос ч юм уу, түүхий тос авах энэний тооцоог хийж үзсэн үү гэсэн хоёр дахь асуудал.

Гурав дахь асуудал, 20 сая доллартой тэнцэх хэмжээний валютыг гэж энэ тоог яаж тооцож гаргасан юм бэ? Манай банк банкнууд дээр гарч байгаа төлбөр тооцооны хэдэн хувь нь банкаар, хэдэн хувь нь хувь юугаар хардаг юм бэ? Энэ тооцоог нь яаж хийсэн бэ?

Ж.Ганбаатар: Гишүүний асуултад хариулъя. Лхагвасүрэн ерөнхийлөгч, 3 номер.

Б.Лхагвасүрэн: Баттөмөр гишүүний асуултад хариулъя. Үүсээд байгаа нөхцөл байдалтай холбоотойгоор бэлэн мөнгийг хил авч гарах ийм мэдээллүүд бол их ирж байгаа. Ялангуяа гаалиас авч байгаа мэдээлэл дотор бол. Тэгээд өнөөдрийн Монгол Улсад байгаа зохицуулалтын хүрээнд бол хэчнээн ч төгрөгийг бол хамаагүй авч явахаар хязгаарласан заалт байхгүй байгаад байгаа юм. Тэгэхээр энэ дээр бол хязгаар тогтооё гэсэн. 20 сая гэдэг төгрөгийг авахдаа бол Мөнгө угаах терроризмтэй тэмцэх хуулийн тэр заалт дотор байгаа 20 гэдэг тоог авсан байгаа. Яагаад гэвэл 20 саяас дээших мөнгө угаах терроризмтэй холбоотойгоор сэжигтэй гүйлгээний тайлан ирүүлдэг энэ 20 сая гэдэг тоо байдаг. Энэ хүрээндээ бол нэгэнт хязгаарлалт байхгүй байгаа учраас энэ хуулийнхаа хүрээнд 20 сая төгрөг хүртэлх хэмжээний бэлэн мөнгө, валют, үнэт металлыг авч гарч болно, энэнээс илүү бол болохгүй л гэсэн ийм хуулийн заалт байгаа юм.

Ж.Ганбаатар: Ёндон сайд бэлдэж байгаарай. Булгантуяа гишүүн.

Х.Булгантуяа: Энэ алт олборлогчдоос өмнөх онуудад энэ ерөнхийдөө далд эдийн засгийг л Лондонгийн металлын хөрөнгийн бирж үнэ дээр байгаа 5 хувийн нэмэгдэлтэйгээр гадаад дотоодын зах зээлээс алт худалдан авч гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлнэ гэж оруулсан байгаа. Тэгээд энүүн дээр бид нар бас нэлээн ярьсан юм. Ингээд 5 хувийн нэмэгдэлтэйгээр яг үнэнийг хэлэхэд энэ нуугдмал байгаад алтны тооцоо байна уу гэсэн, яг үнэндээ бол бас байхгүй байгаа юм байна лээ. Энүүгээр зарим нэг экспортлогчдыг алтыг нь илүү Монголдоо тушаалгах, бага хэмжээтэй ч хамаагүй авч энэ хүнд цаг үед гадаад валютынхаа албан нөөцийг л нэмэгдүүлэх, энэ бол богино хугацааны арга хэмжээ. Энэ бол урт хугацаандаа бол буруу.

Үүн дээр би бас ганц хоёр зүйлийг бүр онцлон хэлэх гэсэн юм. Энэнийг манай Ди парламент аппликэйшнээр хүмүүсээс маш их идэвхтэй санал ирүүлсэн байна, Ганбаатар дарга аа. Үүн дээр бол жишээлбэл Болдбаатар гэдэг хүн энэ 5 хувийн гэдгийг 5 хүртэл хувь гэж тавих нь зөв зүйтэй юм биш үү, жишээлбэл магадгүй.

Ж.Ганбаатар: Ёндон сайд гишүүний асуултад хариулъя. Ажлын хэсгийн 1 номер.

Г.Ёндон: Баттөмөр гишүүний асуултад хариулъя. Манай энэ тос бол ер нь бол хөнгөн тосонд ордог юм. Яг гадаадын тосуудтай чанараараа харьцуулж үзэх юм бол бүр Арабын тосноос ч дутахгүй шахуу сайн чанартай гэж тооцогддог юм байна лээ, хими, физикийн шинж чанараараа. Харин парафинлаг чанар бол нэлээн өндөртэй. Үндсэндээ бол ерөөний температур буюу 20 градуст царцдаг гэсэн тийм зүйлүүд ярьдаг. Би бол өөрөө гар дээрээ хэрэглэж үзээгүй парафилинлаг чанартай. Газрын тосыг бол энэ дамжуулах хоолойгоор тээвэрлэх гэдэг бол энэ бол ерөөсөө бүр манайд бол ийм маргаан жоохон яваад байдаг. Бусад газар бол маргаан битгий хэл энэ ерөөсөө нэг талдаа гарчихсан асуудал юм байна лээ. Жишээ нь, Америкийн Нэгдсэн Улс бол ерөөсөө газрынхаа хэвлийдээ дамжуулах хоолой нь бүр ийм битүү сүлжээ, авто машинаас илүү шигүү сүлжээтэй, дандаа дамжуулах хоолойгоор явуулдаг юм

байна лээ. Харин нэг онцлог нь болохоороо л тосныхоо өтгөн, шингэн чанараасаа хамаараад энэ зөвхөн дамжуулах.

Ж.Ганбаатар: Гишүүдийн асуултад хариулахдаа гүйцээж хариулъя. Энхбаяр гишүүн асуулт асууя.

Б.Энхбаяр: Одоо бидний санал хураах гэж байгаа ажлын хэсгээс оруулж ирсэн саналын томъёоллын 5-д, хуулийн төслийн 5.1.3 дахь заалтыг өөрчлөх санал хураах гэж байна. Энэ хураах гэж байгаа саналаас би 5.1.3-т бөгөөд банк ашиг олох зорилгоор арилжаа хийхийг хориглоно гэдэг ийм заалтыг тодруулж асуух гээд байна л даа. Тэгэхээр банк чинь угаасаа ашгийн төлөө байгууллага. Банк ашиг олох зорилгоор энэ валютын арилжаа хийхийг хориглоно гэдэг чинь банк ерөөсөө валют зарахгүй, авахгүй гэсэн үг үү? Энэ хууль гарахаар тэгэхээр яах билээ? Валютын арилжаа огт хийхгүй болох гэж байгаа юм уу, банкнууд. Хэрвээ энэ банкнууд валютын арилжаа хийвэл тэгээд энэ хориглосон заалтыг зөрчвөл ямар хариуцлага хүлээлгэх юм? Банкыг татан буулгах юм уу, торгох юм уу, даргыг нь захирлыг нь шоронд хийх юм уу? Ямар хууль зүйн хариуцлага яригдах юм бэ гэдэг ийм асуулт байна.

Ж.Ганбаатар: Хэн хариулах вэ? Булгантуяа гишүүн, ажлын хэсгийн саналын томъёоллоос асуулаа.

Х.Булгантуяа: Энэ анх өргөн баригдахдаа бүр банк ашиг олох зорилгоор арилжаа хийхийг хориглох гээд үг бол байгаагүй юм. Тэгээд бид нар зүгээр юу гэж үзсэн бэ гэхээр нэгдүгээрт, энэ бол 3.2.1-д заасан бараа бүтээгдэхүүн гэхээр энэ бол зөвхөн хөнгөлөлттэй нөхцөлөөр нефть, нефтийн бүтээгдэхүүн оруулж ирэхэд санхүү ч дээр репо арилжааны нөхцөлөөр бид нар нэгдүгээрт Монголбанк банкуудад олгоно. Зөвхөн ийм газрын тосны бүтээгдэхүүний хувьд. Энэ нь репо нөхцөл нь, бодлогын хүү дээрээс 0.5 хувьцаатай, банк 3 хувь нэмээд ерөнхийдөө бол хөнгөлөлттэй нөхцөлөөр олгоно гэсэн үг. Бид нар хөнгөлөлттэй нөхцөлөөр ингээд олгоод дээрээс нь ханшийн зөрүүн дээр нь ахиад үүсмэл хэрэгсэл ашиглаад ханшийн зөрүүг нь тогтворжуулж байхад банк түүнийг цааш нь зах зээлийн ханшаар ч байдаг юм уу, бараа бүтээгдэхүүнд ч зориулаад байдаг юм уу, өөр аж ахуйн нэгж байж дундаас нь бидний хөнгөлөлттэй олгож байгаа энэ ханштай зээлийг өөр тийш нь захиран зарцуулж дундаас нь арилжааны ашиг олохгүй гэсэн үг.

Энэ нь бол ерөнхийдөө шууд нефть импортлогч компанийн хүсэлтээр бид нар энэ компаниас энэ данс руу та бүхэн шилжүүлэг хийгээд өгөөч гэхээр банкаараа дамжуулаад л хөнгөлөлттэй нөхцөлөөр цаашаагаа ерөнхийдөө гарах ёстой. Тэр дундаас нь ямар нэгэн байдлаар бидний Засгийн газраас үнэ тогтворжуулах гэж энд оруулж байгаа нөхцөлтэй зээлийг дунд нь арилжаа хийж ашиг олж болохгүй гэж байгаа. Зөвхөн энэ бүтээгдэхүүн дээр зориулж, ийм хөнгөлөлттэй зээлээс. Тэрнээс биш бусад тэр валютын ханшийн арилжаагаа хийх бол нээлттэй шүү дээ. Санкцтай холбоотой Лхагва ерөнхийлөгч хариулах уу? Банкуудтай угаасаа гэрээ хийж байгаа шүү дээ, та бүхэн.

Ж.Ганбаатар: 3 номер.

Б.Лхагвасүрэн: Энхбаяр гишүүний асуултад нэмж тодруулъя. Өнөөдөр хэдийгээр нефть импортлогч нар 45 хоногийн нөөцтэй байгаа ч гэсэн одоо энэ олон улсад үүсээд байгаа нөхцөл байдлаас болоод нефтийн бүтээгдэхүүний үнэ цаашаа өсөх, эсхүл олон улсын хориг цээрээс болоод дахиад гацалт ч юм уу, хомстол үүсэх энэ эрсдэлээс нь сэргийлээд 7 сарын 1 хүртэл нөөц бүрдүүлэх гэж байгаа юм. Тэгэхээр нийтдээ бол дахиад 45 хоногийн нөөц дээрээ дахиад нэмж 45 хоногийн нөөц бүрдүүлэхийн тулд тодорхой эх үүсвэрээр хэрэгтэй. Мэдээж нэг дор бүгдийг нь

бөөнөөр нь авахгүй юм чинь энэ гурван сарын хугацаанд ханшийг нь тогтвортой байлгах үүднээсээ энэ форвард своп хэлцлийг хийх боломжтой, аж ахуйн нэгжүүд нь банктайгаа. Тэгээд тэр ханш нэг тогтвортой ханш тогтчих юм бол энэ дээрээ банкнууд ч гэсэн Монголбанктай хийх боломжтой. Тэгэхдээ энэ дээр нь ийм яг л энэ зорилгоос нь өөр зорилгоор ашиг арбитраж хийх боломжийг хийж болохгүй шүү л гэж ингэж өөрчлөгдсөн ийм заалт гэж харж байгаа юм.

Ж.Ганбаатар: Тиймээс сакс талаас нь асуусан шүү дээ. Тэрийг зөрчвөл яадаг юм бэ гэж. Тэрийг хариул даа.

Б.Лхагвасүрэн: Тийм, ерөнхийдөө бид хэд бол угаасаа Монголбанк өөрөө энэ журмыг зөрчсөн бол Монголбанкны хяналт шалгалтын хэмжээндээ бол тодорхой арга хэмжээ аваад явах боломжтой.

Ж.Ганбаатар: Дараа нь валют нийлүүлэхгүй ч гэдэг юм уу, өчнөөн олон юмнууд байгаа биз дээ, тийм ээ? Энхбаяр гишүүн хариулт хангалттай юу? Энхбаяр гишүүн тодруулъя, 1 минут.

Б.Энхбаяр: Хариултыг бол ойлгочихлоо. Зүгээр хууль зүйн техникийн хувьд, хэрэв тэгвэл сая Булгантуяа гишүүн, Монголбанкны ерөнхийлөгч нарын хариулсан яг тэгж ойлгогдохуйцаар саналын томъёоллыг нь найруулмаар юм байна. Тэгэхгүй бол яг энэ найруулга орохоор банк ерөөсөө валютын арилжаа хийх болохгүй юм шигээр уншигдаад байна. Тийм учраас яг тодотгоход, яг энэ эх үүсвэр дээр нь арилжаа хийж болохгүй гэдгийг нь тодотгож найруулахгүй бол тэгж уншигдаад байна шүү гэдгийг хэлье.

Ж.Ганбаатар: Ажлын хэсэг тэрийг засна биз дээ. Гишүүний саналыг тусгаарай. Ганибал гишүүн асуулт асууя.

Н.Ганибал: Хууль дээр гол асуудал маань эх үүсвэрээ нэмэгдүүлэх үү, нөөц бий болгох уу гээд л ийм л асуудал хоёр асуудлын зааг дээр яваад байна л даа. Махны асуудал дээр хүн болгон бас саналаа хэлээд байгаа юм. Энэ мах бэлтгэн нийлүүлэгч нарт энэ зээл олгоно гээд байгаа юм. Тэгэхээр энэ маань бол үйлдвэрүүдэд мөнгө өгье гэж байгаа юм. Цаана нь орхигдоод байгаа юм болохоор үхрийн махны аж ахуйнууд, хонины махны аж ахуйн, фермер, цаашлаад гахай, тахианы аж ахуйнуудыг яаж бий болгох вэ? Өнөөдөр Монголбанк дээр тэр ханшийн инфляцид нөлөөлөөд байгаа гол асуудал бол хавар энэ шинэ мах гарч ирэнгүүт үнэ гарч ирээд энэ хоёрын намрын үнэ, хаврын үнэ хоёрын зааг маш их интервал өндөр байгаагаас болоод инфляцад нөлөөлөх нөлөөлөл нь өндөр байгаад байгаа л даа. Тэгэхээр энэ дээр Хөдөө аж ахуйн сайдаас асуугаад байна л даа. Зөвхөн мах бэлтгэн нийлүүлэгч нар гээд зөвхөн үйлдвэрүүдэд мөнгө өгчихөөр намар шинэ мах гарч ирэх, энэ үнийг арай бага болгох тал дээр ямар нэгэн шийдэл энэ дотор оруулахгүй юм уу, энэ хуульдаа? Одоо энэ хууль дээр.

Зөвхөн намар бол яах вэ дээ, нөөцийн мах гээд бүх хүмүүс бэлтгэн нийлүүлдэг тэр үед Засгийн газар мөнгө гаргачихаар махны үнийг л өсгөдөг байхгүй юу. Энэ нь өөрөө бодитой. Яагаад гэхээр энд бол хувийн аж ахуйн нэгжүүд өөрсдийнхөө хэмжээнд махыг худалдаж аваад хавар зарж дундаас нь ашиг олдог. Энэ дээр нэмээд Засгийн газар мөнгө гаргаж ирэхээр махны үнэ нэмэгдчихдэг юм. Тэгэхээр энэ дээр та бүхэн бас оношоо зөв тооцооч ээ. Одоо бол яагаад мах өндөр үнэтэй гарч ирээд байгаа юм гэхээр нэгдүгээр асуудал бол мэдээж, малчдын хариулж байгаа малын насжилт их залуужсан. Хуучин бол 30, 40 сая малтай байхад бол эр үхэр, эр хонь гээд намар нийлүүлэлтэд гаргаж ашиг олдог энэ асуудал маань багассан. Харьцангуй намар үнэтэй байгаа учраас нийт малынхаа ихэнх хувийг борлуулдаг

болчихсон. Энэ дээр бид нар шинэ мах, шинэ тэр фермийн аж ахуйнуудын асуудал дээр эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх тэр хүмүүстээ тэр зээлийг нь олговол яасан юм бэ л гэж байгаа юм.

Хоёрт нь тэр эрсдэлгүй газар тариалан руу бид мөнгө хийхгүй бол намар мэдээж гурилын үйлдвэрүүд би улаан буудайгаа л авна шүү дээ. Тэгэхээр эрсдэлгүй их хэмжээгээр, нийлүүлэлт нь л сайн байх юм бол бид бүхэн бас тодорхой хэмжээнд гурилынхаа үнийг бариад байж болно. Яг л адилхан бид нар тэр валют орж ирдэг эх үүсвэрүүдээ яаж нэмэх вэ л гэнэ үү гэхээс, тэр байгаа валютаа яаж нөөцлөх вэ, яаж хадгалах вэ гээд асуудал ингээд эх үүсвэр тал дээрээ илүү анхаарлаа хандуулаач ээ. Би шууд утгаараа хэлэхэд газар тариалангийн газар эрсдэлгүй газар тариалангийн аж ахуйн нэгж рүүгээ зээлээ өгөөч ээ, тэр фермерүүд, хоршоонууд хонины аж ахуйнууддаа зээлээ өгөөд намрын махны нийлүүлэлтээ арай бага үнэтэй гаргаж ирэх энэ бодлогыг бас бариач л гэж бод гэсэн саналыг бас хэлж байна.

Ж.Ганбаатар: Ер нь бол голдуу санал уу? Ганибал гишүүнд баярлалаа, санал хэллээ. Гишүүний саналыг анхаарч ажиллаарай, махтай холбоотой гол саналуудыг хэллээ. Салбарын сайд, Монголбанк. Цэрэнпунцаг гишүүн асуулт асууя.

Ц.Цэрэнпунцаг: Хоёр асуулт байна. Нэгд, энэ махны нөөц яг жилдээ манайх чинь хэдийг нөөцөлдөг юм бэ? Энэ нөөцөлж байгаа хэмжээ нь яагаад хэд гэдэг тоогоо ямар шалтгаанаар тавьдаг юм? Бид нарын нөөцлөх нөөцийн сав маань ийм хэмжээтэй байдаг юм уу? Ямар учиртай юм?

Хоёрт бид нар удаан хугацаандаа бол өчнөөн жил 20, 30 жил ярьсан юм чинь фермерээ хөгжүүлнэ гээд л энэ махны нийлүүлэлтээс үүдэлтэй махны үнэ нэмэгддэг юм байгаа байхгүй юу. Тэгээд л намар болохоор элбэгшээд нийлүүлэлт нэмэгдчихээрээ жоохон буураад л, тэгээд л ховордоод хавар болоод ирэхээр ингээд л үнэд ороод ирдэг. Тэгээд л нөгөө 60, 70 сая малтай байж байж яагаад ингээд байна гээд л нөгөө асуудал чинь жил болгон гараад энэ чинь 20, 30 жил явж байна шүү дээ. Тэгэхээр энийг бол өнөөдөр бид нар түр зуурын ийм асуудал гарч ирэхээр зэрэг давхар шийдэх асуудал биш байхгүй юу. Хамгийн гол нь бид нар энэ богино хугацаанд энэ нөөцөө бид нар ахиухан шиг, Мэндсайхан сайд аа, нөөцийнхөө боломжийг нэмэх, хөргөгч, зоорио энэ хугацаанд харин нэмээд энэ намар бид нар нөөц ахиухан шиг аваад, хойтон жил дахиад л хавар болно. Дахиад л энэ махны асуудал гараад ирнэ. Тэрний дараа 2024 онд бүр хурц тавигдана. Тэгэхээр энэний нөөцийг нь нэмэх ямар боломж байгаа юм?

Хоёрт, бензин тосныхоо нөөцийг 45 хоногоор гээд хоног тавьчихаад байна. Энэ нь бас одоо бас нөөцийнхөө саавай холбоотой байдаг юм уу? Заавал 45 хоног биш, 90 хоног биш 180 хоног ч юм уу, ингээд нөөцөд авна гээд. Нөөцийн сав нь боломжгүй байдаг юм уу, ямар учиртай юм энэ 45 хоног гэсэн нь? Би тэгээд нэмэлт цаг авч байгаад асууя. Энэ хоёр дээр хариулт авъя даа.

Ж.Ганбаатар: Хэн хариулах вэ? Мэндсайхан сайд, ажлын хэсгийн 2 номер.

3.Мэндсайхан: Цэрэнпунцаг гишүүний асуултад хариулъя. Өнгөрсөн жил жишээ нь бид нар 100 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг мах бэлтгэлд гаргасан юм. Энүүгээрээ бид нар нийтдээ 23 аж ахуйн нэгж 98 тэрбум төгрөгийн зээл аваад 12.6 мянган тонн мах бэлдсэн байна. Улаанбаатар хотын махны хэрэглээ бол өдөрт 110-140 тонн мах хэрэглэж байгаа юм. Одоо бол хаврын улиралд бид нар энэ махны энэ нөөцийг яагаад бүрдүүлэх гээд байна гэхээр бид нар дөрвөн улиралтай. Хаврын улиралд бол намрын 10 сарын сүүлээс эхлээд мах бэлтгэл чинь 1 сарын 20 хүртэл явагдаж байгаа. Ингээд 1 сарын 20-ноос хойш мах бэлтгэлийн хугацаа боломжгүй. Бид

нар уламжлалт бэлчээрийн мал аж ахуйтай учраас мал маань хавар турж эцэх ийм асуудал байгаа. Ингээд шинэ мах бол 7 сарын 10-д хүрч гарч ирж байгаа, цаг уурын нөхцөл байдлаасаа хамаараад.

Энэ хугацааны таван сарын махны нөөц нийлүүлэлт талдаа доголдол үүсдэг. Өнөөдөр гэхэд жишээ нь өдөрт шинэ мах бол дунджаар 20-25 тонн л орж ирж байна, Улаанбаатар хот руу. Энэ зөрүү хаврын энэ хомстлыг аж ахуйн нэгжүүддээ дэмжлэг болгох зорилгоор бид нар эх үүсвэр гаргаж өгч байгаа. Агуулах, нөөц талдаа гэх юм бол махны талдаа бид нарт хадгалах сав зоорь бол хангалттай, аж ахуйн хувийн хэвшил дээр маань байгаа. Тэгэхээр хувийн хэвشلүүддээ бид нар харин эргэлтийн хөрөнгө буюу мах бэлтгэлийн зардлыг эрт гаргаж өгье, төлөвлөлтөө эрт хий гэдэг байдлаар л энэ хууль дээр махны асуудлаа оруулж ирж эх үүсвэрээ шийдээд явж байгаа.

Ж.Ганбаатар: Ёндон сайд, 1 номер.

Г.Ёндон: Түрүүний асуултыг бас дуусгачихъя. Тэр дамжуулах хоолойн талаар бол хэлсэн. Хоолойны диаметрээс хамаараад өтгөн тос, нарийн тосыг бол, өтгөн байх тусмаа диаметр нь өргөн болоод явдаг. Саяын гэрээ байгуулсан Хятадын компанийн санал бол 250 диаметртэй байхад 388 сая доллар, 305 диаметртэй болговол 397 сая доллар гэсэн ийм санал ирсэн учраас бид нар илүү өргөн диаметрийг сонгож авсан байж байгаа.

Баттөмөр гишүүн асуусан, өөрсдийнхөө тосыг гадагшаа гаргах уу эсвэл энийгээ дотроо хэрэглэх үү гээд. Мэдээж өөрийн боловсруулах үйлдвэрт ашиглах нь хамаагүй ашигтай. Яагаад гэвэл бид нар урагшаа гаргаад, тээвэрлээд тээвэрлээд дээрээс нь урд тэвшинд шингээгээд буцаагаад манайх худалдаж авна. Компанийн худалдаж авч байгаа компанийн ашиг нэмэгдэнэ. Хойноос мөн яг адилхан. Тийм учраас энэ премиум нэмэгддэг. Одоо Оросын Холбооны Улсаас авч байгаа үнэ дээр нэмэгддэг премиум болон эдгээр үнийг бол бид нар нэмэхгүйгээр зарах юм бол Монголын дотоодын боловсруулах үйлдвэрийн үнэ бол 15 орчим хувиар хямдхан байх боломжтой байж байгаа.

Цэрэнпунцаг гишүүний асуултад хариулъя. Нөөцийн хувьд бол Монгол Улсын газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 18.3 гэж заалтаар бол газрын тосны бүтээгдэхүүний нөөц бол улсын нөөц болон компанийн нөөцөөс бүрдэнэ гэсэн байдаг. Компанийн нөөц бол яах аргагүй энэ бол савнаасаа болж байгаа. Манай тал болохоор эдгээр улсын нөөцийг бол өөрийн сав байхгүй учраас энийг бол компаниуд дээр хадгалуулдаг. Сэлгэн хадгалах гэсэн журмаар хадгалуулдаг. Компанийн нөөц бол өмнө нь 30 хоног байсан. Өнгөрсөн есөн сараас хойш бол энэ асуудлыг хэлэлцээд 2021 оны 10 сарын 16-ны 311 дүгээр тогтоол гараад 30 хоногийн компанийн нөөцийг бид нар 45 хоног болгосон. Бас энэ бол тодорхой хэмжээгээр уршигтай. Яагаад гэвэл нэгдүгээрт компаниуд энэ нөөцөө бүрдүүлээд хүссэн нөөцийг удаан хугацаагаар, гурван сараар ч юм уу хадгалах хэмжээгээр өөрчлөлт явагддаг. Бас хадгалалтын зардал гээд асуудлууд байдаг гэсэн асуудал яригддаг. Мэдээж хүүтэй мөнгө зээлдэг учраас бол бас гурван сарын хүүтэй мөнгө бол мөнгө нь ингээд гацаад байдаг учраас.

Ж.Ганбаатар: Цэрэнпунцаг гишүүн 1 минут тодруулъя.

Ц.Цэрэнпунцаг: Ёндон сайдаас тодруулчихъя. Бид нар улсынхаа нөөцийн тэр саваа энэ хугацаанд харин нэмээд, улсынхаа нөөц дээр гол нь анхаараад, тэрэн дээрээ хар дагуулахгүй мөнгө төгрөгөө гаргаад ингээд засаг нь жоохон нөөцөө нэмээд, тэгээд энийгээ буцаагаад зах зээл рүүгээ тохируулагч маягтай оруулах арга хэмжээ авбал бас нэг иймэрхүү тулгамдсан үед хэрэгтэй байх юм биш

үү. Энэ дээр ямар нэгэн ажил хийх, энэ дээр яг энэ хуультай холбоотой, энэ хуульд оруулаад ч юм уу, энэ нөөцийнхөө савыг нэмэх дээр янз бүрийн төсөв мөсөв тавьж байгаад нэг ийм шийдэл гаргаад ингээд оруулчхаж болохгүй юм уу? Энэ хуульд тийм юм харагдахгүй байх шиг байгаа юм.

Ж.Ганбаатар: Ажлын хэсгийн 1 номер, Ёндон сайд гишүүний асуултад хариулъя.

Г.Ёндон: Нэгдүгээрт, улсын нөөцтэй байна гэдгийг бол яам бүх талаар дэмждэг. Энэ талаар саналыг ч үе, үеийн Засгийн газрын хуралдаанд оруулдаг. Ер нь бол 100 хувийн импортын хамааралтай манай улс битгий хэл үйлдвэрлэдэг улсууд өөрсдөө нөөц хадгалдаг, улсын нөөц хадгалдаг. Гэхдээ онцлог нь бол голцуу түүхий тос байдлаар хадгалдаг. Түүхий тосон дээр бол ууршилт ч бага байдаг. Ер нь бол илүү нэг янзын байдаг. Түүхий тосноосоо олон янзын бүтээгдэхүүн гаргаж авдаг учраас олон янзын бэлэн бүтээгдэхүүн хадгалах нь бол ууршилт, олон янзын асуудал байдаг. Америкийн Нэгдсэн Улсад гэхэд 95 хоногийн нөөцтэй байх жишээтэй. Хятад улс адилхан мөн адилхан 3 сарын нөөцтэй байх жишээтэй. Энэ тал дээр бол манайхаас бол улсын нөөцийн рашаантай савны концесс гээд нэг урт хугацаатай концесс байдаг. Бид бүхэн сая 2021 оны 12 сарын 31-нээр энэ концессыг хэрвээ үнэхээр хөрөнгө оруулалтаа оруулж ирээд 100 мянган метр/кубын багтаамжтай рашаантай тийм нөөцийн сав барих тендер.

Ж.Ганбаатар: Хүрэлбаатар гишүүн асуулт асууя.

Ч.Хүрэлбаатар: Би хэдэн зүйл хэлэх гэсэн юм. Яагаад гэхээр яг одоо болоод байгаа процесс яг ямар юм болоод байгаа юм бэ гэдгийг бид нар том зургаар нь харж чадахгүй бол зөв шийдвэрүүд гаргаж чадахгүй. Одоо Монгол Улс битгий хэл дэлхий нийтээр болоод байгаа энэ үзэгдлийг бол эдийн засаг тэр стикуляци гэж нэрлэдэг. Өндөр өсөлтөө, үнийн өндөр өсөлттэй инфляцтай, эдийн засгийн өсөлт нь бага байх ийм процессыг хэлдэг. Энэ бол дэлхийн улс орнуудын хувьд бол 1970- аад оны үеийн процесс. Тэгэхээр ийм үед ямар арга хэмжээ авдаг вэ гэдгийг Засгийн газар, Монголбанк сайн үзээч. Тэгэхгүй бол та нар ингээд яг тэс хөндлөн, буруу юм яриад тэгээд л улам нөхцөл байдлыг хүндрүүлээд байна. Тэгэхээр тэр стикуляци гэж хэлэгддэг тэр зүйлийг та бүгд сайн судал. Ийм үед ямар арга хэмжээ авдаг вэ гээд. Тэрийг мэддэг бол, судлаад үзчихсэн бол өнөөдрийнх шиг ийм юм орж ирэхгүй. Үр дүн багатай зүйлүүд чинь хоосон л үр дүн авчирна шүү дээ. Дараа нь бөөн хэл ам. Тэгэхээр энийгээ сайн судлаач. Одоо мэдэхгүй бол мэдэж авцгаа тэр үгэн дээрээ. Тэгчхээд бодлогын арга хэмжээнүүдээ яриарай гэдгийг би онцлоод хэлчихье.

Хоёрдугаарт нь, энэ дээр Халтар сайд хаана байна? Инфляцад хоёр гол зүйл л нөлөөлнө, одоо. Нэгдүгээрт, тээвэрт зууч. Урд талд Хятадын хил бараг хаалттай байгаа. Дээр нь дайнтай холбоотойгоор Орос буюу Европоос орж ирэх хил бас хүндрэлтэй байдалд орчхож байгаа юм. Ийм нөхцөлд тээвэр зуучлал бол номер 1. Хятадын хилүүд хэзээ хэвийн байдалд орох юм, энд байгаа нөхцөл байдлыг яаж сайжруулах вэ гээд Халтар сайдаас би өнөөдөр асуумаар байна. Зугтаад байх юм. Европ дээр тавигдаж байгаа, Орос дээр тавигдаж байгаа санкцуудтай холбоотойгоор Европын машинууд Монгол руу орж ирэх боломжгүй болчхож байгаа, одоо. Тэгэхээр энэ нөхцөлд бид нар яах ёстой юм, тээвэр, төмөр зам нь ямар байгаа юм гэх мэтийн зүйлээ ярих ёстой. Тэгээд байхгүй. Энэ бол инфляцад голлож нөлөөлөх зүйл. Энүүнийхээ асуудлыг сайн шийдэж явахгүй бол энэ инфляц цаашаа улам л нэмэгдэнэ.

Дараагийн асуудал бол энэ ханш. Монголбанкны ерөнхийлөгч Лхагвасүрээн энд тэнд хүмүүсийг шүүмжилчихлээ гээд шүүх, цагдаад өг гэдэг, эрүүгийн цагдаа, дүүргийн writer.chimege.mn яриаг бичвэрт хөрвүүлэв.

цагдаа, нийслэлийн цагдаа бүгдэд нь өгч солиорч явж байхаар чи наад ханшаа яаж зөв болгох вэ гэдэг дээр анхаарлаа хандуул. Монгол Улс хэзээ ийм хоёр ханштай явж ирсэн юм? Энэ ханш чинь импортын бараагаар дамжиж Монголд инфляц болж явж байгаа. Ханш уналт. Тэгэхээр Лхагвасүрэн энэ ханшаа хэзээ, яаж цэгцлэх юм, хэзээ хоёр ханшаа болих юм, хэзээ наад бодлогуудаа зөв болгож явах юм? Яг энэ ханшийн байдлыг хэзээ тогтворжуулах юм. Ард түмэн тийм л юм асуугаад байна шүү дээ. Энэ тээвэр хэзээ хэн болох юм, хэзээ энэ ханш ингээд хязгаарлалт өгдөг дабл стандарт энэ дээр гараад байгаа зүйлийг зогсоож өгөөч гэж ийм л зүйл хэлээд байгаа юм.

Би бол бүлгийн хурал дээр хэлсэн. Халтар дээр хариуцлага тооц, Лхагвасүрэн дээр хариуцлага тооц гэж. Одоо дахиад хэлж байна. Би хариуцлага тооцохгүй удах тусмаа л энэ асуудал улам л угжрах, хүндэрнэ. Мэддэг хүнээ тавьж явахгүй бол мэдэхгүй хүмүүсээр явуулсаар байгаад энэ чинь улс орон дууслаа шүү дээ. Энэ инфляц ч гэсэн дээшээ бүр явж байна шүү дээ. Та бүгд эргээд үзээрэй. Тэр өнгөрсөн оны 10 сард энэ инфляц дээшээ явна шүү гэж хэлээд байхад л арга хэмжээ аваагүй. Халтарыг дуудаж хариултаа авъя, Лхагвасүрэн.

Ж.Ганбаатар: Халтар сайд руу би бас утсаар ярьчихсан байгаа. Зүгээр яах вэ, өөрт байгаа мэдээллээр хэлэхэд бол Оросын буюу Европын Холбооны тал Орос, Беларусийн номертой машинуудыг нэвтрүүлэхгүй байгаа юм байна лээ л дээ. Тийм буцаагаад тэгэхээр Орос болохоор Европын машинуудыг /ТИР-үүдийг ярьж байгаа шүү дээ/ нэвтрүүлэхгүй гээд тийм. Тэгэхээр Гадаад яам бас идэвхтэй ажиллавал уул нь бол Станы улсууд руу бол чөлөөтэй явж байгаа юм байна лээ. Тэгэхээр манайх ингээд яг үеийн, үед ингээд санаачилгатай ажилладаггүй байхгүй юу. Гадаад яам сайн ажиллаад наад эм, тариа хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг тэр лацтай машинаар явуулна гэдэг дээр хүсэлт тавиад явбал болохгүй юм байхгүй л юм байна лээ.

Хоёр дахь гарц нь юу байна гэхээр энэ Станын улсуудын энэ Казах гэдэг юм уу, Узбекистаны номертой машинууд бас явах боломжтой. Энийг бас тээврийн компаниуд бас сайн судалж үзэх ёстой юм байна лээ шүү. Гадаад харилцааны сайд энэ талаар бол санаачилгатай ажиллаад, энд Жавхлан сайд бас асууж байгаа юм чинь энийг бас сайн. Тэгэхгүй бол Европоос явж байгаа хүнсний бүтээгдэхүүнүүд эм, тариа гэдэг юм уу, бусад юм саатвал их том асуудлууд үүснэ, хоёр талаасаа хаалттай болчихно. Тэгэхээр энэ талаар бол аль, аль талд нь Оросын талд ч ялгаагүй, Европын Холбооны талд ч ялгаагүй Станы улсууд явж байна. Одоо боломжтой байна гэж байна шүү дээ. Тэр битгий хэл, Хойд Солонгосын ачаанууд хүртэл яваад байгаа юм шүү, хүнстэй холбоотой. Тийм, тийм юмнууд дээрээ бас анхаарлаа хандуулна биз дээ. Монголбанкны ерөнхийлөгч гишүүний асуултад хариулъя. Халтар сайдыг дуудсан ороод ирж магадгүй байх.

Б.Лхагвасүрэн: Хүрэлбаатар гишүүний асуултад хариулъя. Өнөөдөр инфляц бол 14 хувьтай байна. Тэгэхдээ Монголбанк бол энэ инфляцыг бол эрэлтийн шинжтэй гэхээсээ илүү нийлүүлэлтийн шинжтэй, ялангуяа КОВИД-оос үүссэн тээвэр ложистикийн асуудал, энэ хил, гааль дээр байгаа гацалтын асуудлаас болж барааны хомстол үүсээд энэ хэмжээгээр ингээд үнэ өсөөд явж байна гэж харж байгаа.

Хоёрдугаарт гэвэл, Монгол Улсын хэрэглээний сагсны инфляцыг тооцдог бараа бүтээгдэхүүний бараг тал нь буюу 50 орчим хувь нь импортын бараа байгаа. Тэгэхээр импортын бараан дээр байгаа инфляц бол яг одоохондоо илүү их, дэлхийн зах зээл дээр хүнсний үнэ нь өөрөө 30 хувь өсчихсөн, тодорхой хэмжээний барааны хомстлоосоо болоод ийм нийлүүлэлтийн шинжтэйгээр, дэлхийн зах зээлийнх нь үнэ өсчихсөн гэдгээрээ инфляц маань импортлогдож орж ирж байгаа. Тэгэхээр Төв банкны хувьд бол яг мөнгөний бодлогоороо яг өнөөдрийн энэ нийлүүлэлтийн шинжтэй

инфляцтай бол шууд ингэж яах арга хэмжээ, арга хэрэгсэл бол байхгүй. Бидний хувьд бол дунд хугацааны буюу энэ оны төгсгөлд инфляцыг тогтворжуулах гэдэг утгаараа өнөөдрийн бодлогын хүүгээ бол нэмээд явж байгаа.

Ханшийн хувьд бол би урьд нь бас хариулж байсан. Өнөөдөр банк хоорондын зах зээл дээр буюу бэлэн бус валютын зах бэлэн бус гэдэг, гадаад төлбөр тооцоонд явж байгаа. Тэрний эрэлттэй холбоотой Монголбанк бол тодорхой хэмжээгээр интервенц хийгээд нийлүүлээд явж байна. Өчигдөр бол 80 сая долларыг бол банкнуудад өгсөн. Тэр хэмжээгээр бол гадагшаа хийгдэж байгаа бүх гэрээтэй төлбөр тооцоонууд бол ингээд хийгдээд явж байгаа. Өөр нэг бэлэн буюу банк бусын Найман шарга гэж нэртэй зах байгаа. Тэрэн дээр бол дандаа бэлэн валют авах л ийм эрэлт үүсчихээд байгаа.

Бэлэн валют гэдэг маань өөрөө доллар. Доллар гэдэг бол бас л бусад бараатай адилхан бараа. Монгол Улсад бас импортоор л банкнууд авчирдаг. Өөрийнхөө харилцагч банкнаасаа авчраад тэгээд харилцаад. Тэрэн дээр нь мэдээж бас тодорхой хэмжээний хомстол үүссэн учраас банкнууд бол өөрөөсөө арай бага хэмжээгээр харилцагчтай нийлүүлж байгаа. Нөгөө бэлэнгийн одоо тэр Найман шарга гэдэг зах дээр нь тэнд бас тодорхой хэмжээний бас хомстол үүссэн учраас бол тэр хэмжээгээрээ арай өөр ханш явж байгаа. Тэгэхдээ одоо долоо хоногийн өмнөхөөс энэ хоёр ханш бол хоорондоо ойртож байгаа. Монголбанкны өнөөдрийн зарлаж байгаа ханш бол 3034 төгрөг байгаа. Найман шаргын гэдэг банк бусын зах дээр байгаа ханшийг сонсоход бол 3150 гэсэн ийм ханш мэдээ ирж байгаа юм.

Ж.Ганбаатар: Хүрэлбаатар гишүүн тодруулъя.

Ч.Хүрэлбаатар: Лхагвасүрэн ерөнхийлөгч өө, одоо дахиад л та яг энэ үлгэрээ давтаж байна. Мөнгөний бодлогод огт хамаагүй, инфляцад хамаагүй гэж яаж амнаас чинь гарч чадаж байна аа? Чи бол эдийн засагч хүн биш. Хүнд өвчтэй хүнд хагалгааг мэргэжлийн эмч хийдэг болохоос биш мэргэжлийн хяналтын байцаагч хийхгүй шүү дээ, ер нь бол. Ийм буруу юм хийж явсаар байгаад энэ улс орны эдийн засгийг ингээд унагааж байна шүү гэдгийг би удаа дараа хэлээд л байгаа юм. Дахиад ч хэлнэ. Энэ байдлаараа бид нар өөд нар үзэхгүй. Би хэрвээ чиний оронд байсан бол аль хэдийн өргөдлөө өгөөд зайлна, эндээс, Монголын төрөөс. Чи 3.4 сая хүний амьдралыг там болгочоод, тэгээд ичихгүй яаж наанаа ингээд суугаад байж чадна аа? Халтар та хоёр болих хэрэгтэй шүү дээ, ер нь. Тэгээд Байнгын хорооны даргын тээвэр зуучлал бол Батцэцэг сайдын ажил биш шүү дээ. Халтарын ажил.

Ж.Ганбаатар: Доржханд гишүүн асуулт асууя.

Т.Доржханд: Баярлалаа. Ингээд маш яаралтайгаар ажлын хэсэг байгуулагдсан. Шалтгаан нь юу юм бэ гэсэн, залуучууд хоёр өдөр ордны өмнө жагссан. Гол уриа нь юу байсан бэ гэхээр өөрсдөө хэмнэ гэж. Өөрсдөө л хэмнэ, ажлаа хий. Тэгээд эдийн засгийн нөхцөл байдал хэцүү байна, тийм болохоор гадагшаа явмааргүй байна, Монголдоо сайхан амьдармаар байна аа. Тэгш боломж авмаар байна, тэгээд та нар ажлаа хийгээд өгөөч ээ л гэж байгаа юм. Тэрний дагуу Улсын Их Хурлын чуулган дээр ярьж байгаад маш яаралтайгаар, Улсын Их Хурлын даргын зүгээс бол ажлын хэсэг байгуулъя, тэгээд хурдан энэ асуудлыг шийдье гээд. Тэгээд тэрийг бол би маш уриалгаар хүлээж авсан хүн. Намын даргын хувьд, мөн цөөнхийг төлөөлж байгаа Улсын Их Хурлын гишүүний хувьд ажлын хэсэгт нь орж ажилласан. Хагас сайн, бүтэн сайнд бид нар бүтэн өдөржингөө л ажиллаад суусан шүү дээ.

Одоо миний асуулт. Ажлын хэсгийн уулзалтаар бид нар ер нь хэмнэнэ гэдэг нь бол зүйтэй байна. Одоо энэ асуудлыг үр дүнтэйгээр бүгдээрээ хэмнэлтээсээ эхэлье

гээд Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулаад, түүн дээр төр яаж хэмнэх юм, төсвийн зарлага чиглэлээр яаж бууруулах юм, мөн орлого талд ямар боломж байгаа юм. Өөрөөр хэлэх юм бол архи, тамхины онцгой албан татварыг өсгөх боломж нь байна уу? Дэлхийн түвшнээс татварынх нь хэмжээ нь 4-8 дахин бага ийм орчинд бид нар явж байгаа нь зөв үү? Одоо энийгээ хийгээд авъя.

Олон улсын эдийн засаг дээр дэлхийн улсуудын дундаж төсвийнх нь хэмжээ нийт эдийн засгийнхаа 15-20 хувь байдаг бол Монгол Улсын эдийн засагт оролцох төсвийн хэмжээ 40 хувь болчихоод байна. Сүүлийн 30 жилийн хугацаанд Монгол Улсын эдийн засаг 15 дахин өссөн бол Монголын төсөв 55 дахин өссөн байна. Хямрал явах болгонд л төсвөө тэлж байдаг, эдийн засаг хөгжих болгонд л төсвөө тэлж байдаг. Сүүлийн 32 жилийн хугацаанд төсөв агшсан нэг ч тохиолдол байхгүй. Энэ бол том үрэлгэн төрийн тогтолцоо. Ийм болохоор маш зоригтойгоор шинэчлэлээ хийе. Чиг рүү чиглэлээ, төсвийн асуудлаар Монголбанкны зүгээс юу хийх вэ гэдэг асуудлаар тов тодорхой, Улсын Их Хурал нь Засгийн газарт чиглэл өгье гээд бид нар суусан, ажилласан. Өглөөнөөс орой хүртэл суусан. Тэр хаана байна аа? Ажлын хэсгийн дарга аа, хаана байна? Тэгээд энэ асуудал байхгүй болсон бол намайг тэгж яах гэж ажлын хэсэгт оруулсан юм. Одоо тэр тогтоолын төсөлд нь байхгүй байна шүү дээ. Одоо энэ төсвийн тодотголоо яаж хийх гээд байгаа юм. Улсын Их Хурал нь чиглэлээ өгдөггүй юм уу?

Хоёр, залуучууд чинь ингээд /ордонд/ жагсаад, та нараас үр дүн хүсээд байна шүү дээ. Тэгээд Ерөнхий сайд нь гарч ирээд бид нар энийг шийднэ гээд, Их Хурлын дарга нь яаралтай ажлын хэсэг байгуулъя гээд. Энэ орж ирж байгаа юм нь ердөө нөгөө л нэг гол нэрийн бүтээгдэхүүнүүд гээд гурван бүтээгдэхүүн л асуудал ярьж байна шүү дээ. Тэгээд энэ жил үнэ тогтворжуулах биш, эрх жилийн л нөөцийн асуудал юм байна лээ шүү дээ, яг үнэнээ хэлэхэд. Тийм болохоор энэ дээр нэгдүгээрт хариултаа авмаар байна. Тодотгол хэзээ, яаж орох юм? Тэгээд чиглэл өгөх юм уу, өгөхгүй юм уу? Улсын Их Хурал нь ажлаа хийх юм уу, хийхгүй юм уу?

Хоёрт нь, 5.1.3-ыг ажлын хэсэг дээр яриад хасъя гэсэн. Тэгсэн, арай өөр байдлаар ороод ирчихсэн байна. Энэ гадаад валютын ханшийн эрсдэлийг шууд ингэж хүлээж авахаа больё. Энийгээ бол шаардлагатай бол хүүгийн хөнгөлөлт байдлаар үзүүлнэ гэж ажлын хэсэг дээр тохирсон. Энэ маань өөрчлөгдсөн байна.

Дараагийнх нь Лхагвасүрэн ерөнхийлөгч өө, 5.1.6 дээр 5 хувийг илүү төлөлтөөр алт худалдаж авъя гэсэн ийм санал орж ирээд байна. 5 гэдэг тоо чинь хаанаас гарч ирсэн юм. Гаднын хүмүүс Монголд ирж алтаа тушаана гэсэн үндэслэлээр алт, валютынхаа нөөцийг өсгөнө гэдэг ийм төсөөлөл хийгээд байна уу? Энэ дээр тодорхой хариулт.

Ж.Ганбаатар: Мэндсайхан сайд Их Хурлын даргын уулзалт руу явж бай даа. Асуулт дуусаж байгаа учраас. Сайдуудыг би бол заавал байн байлгая гэдэггүй шүү дээ. Ер нь бол Засгийн газраас өргөж байгаа асуудал дээрээ л өөрсдөө тайлбараа хийх бүр хуультай шүү дээ. Тэгээд сайд өөрөө уншина, танилцуулгаа өөрсдөө хийнэ. Тэгээд сайн ойлгохгүй бол, Байнгын хороо заавал суу гээд байдаг юм бол биш шүү. Жавхлан сайд гишүүний асуултад хариулъя.

Б.Жавхлан: Доржханд гишүүний асуултад хариулъя. Улсын Их Хурлын даргаас шуурхай арга хэмжээ аваад Их Хурлын гишүүдээс бүрдсэн ажлын хэсэг хагас сайн, бүэн сайнгүй ажилласан. Тэгээд Засгийн газраас өргөн барьсан асуудлууд дээр ингэж ач холбогдол өгч ажиллаж байгаад талархал илэрхийлье, Засгийн газрынхаа өмнөөс.

Ингэж байгаа шүү Доржханд гишүүн ээ, өнөөдөр яг энэ долоо хоногт тавьсан даргын зөвлөл дээрх хуваариараа эхлээд энэ өргөн барьсан хууль орж ирж байгаа. Өнөөдөр, яг одоо Засгийн газрын хуралдаан болж байна. Засгийн газрын хуралдаан дээр бид тодотголынхоо төслийг ярьж байгаа юм. Ямар байдлаар, ямар зарчмаар хэмнэх вэ гээд. Хагас сайн, бүтэн сайнд ажлын хэсэг дээр яригдсан тогтоолын төслөө ерөнхийд нь яг тодотгол руу оруулах хэсгийг нь оруулаад, төсвийн тодотгол бас хууль болж гарна. Тэгэхээр хууль дагасан тогтоол дээрээ бас оруулах хэлбэрээр ингээд хэлбэржүүлээд явж байгаа. Өнөөдөр Засгийн газар дээр бид төслөө хэлэлцээд хэзээ өргөн барихаа шийднэ. Тэгэхээр амжвал энэ долоо хоногт, амжихгүй бол ирэх долоо хоногийн эхээр Засгийн газрын өргөн барихад бэлэн болно. Ер нь бол ажлын хэсэг дээр яригдсан хэмнэлтийн болон тэвчиж болох хөрөнгө оруулалтын зардлууд гээд бид нарын гол зорилго бол энэ жилийн бас нөхцөл байдлаас болоод орлого тасалдаж болзошгүй ийм эрсдэл гарч болзошгүй учраас энэ жилийн хувьд зардал тал дээр урсгал зардал дээр ч тэр, хөрөнгө оруулалтын зардал дээр ч тэр ер нь эргэж харъя гэсэн ийм логигоор тодотгол орж ирнэ.

Ж.Ганбаатар: Лхагвасүрэн ерөнхийлөгч гишүүний асуултад хариулъя. 3 номер.

Б.Лхагвасүрэн: Доржханд гишүүний асуултад хариулъя. Монголбанкны хувьд бол хуулиараа бол алт худалдаж авдаг. Тэгээд экспортолж валютын нөөцөө нэмэгдүүлж байгаа юм. Ерөнхийдөө өнгөрсөн онд бол 20 тонн алт авсан. Энэ жил бол одоо энэ 20 тонн алтаа нэмэгдүүлэх зорилготой явж байгаа юм. Тэгээд ерөнхийдөө бас Ашигт малтмалын тухай хууль дотор тухайн жилд олсон алтаа тухайн жилдээ тушаах ёстой гэдгээрээ бас нэг хуулийн зохицуулалт байдаг юм л дээ. Тэгэхээр өнгөрсөн онуудад тэр тушаагдаж чадаагүй тийм алтны нөөц байх боломжтой гэдгээрээ бас тийм мэдээллүүд явж байсан. Банк бус санхүүгийн байгууллагууд болон банкнуудад алтыг барьцаа болгож тавиад бас богино хугацааны зээл аваад явдаг ийм бүтээгдэхүүн юмнууд байна гэж бас мэдээлэл, статистик тоо байгаа. Энэ хүрээндээ хэрвээ өнгөрсөн онд тушаагдаагүй алт байвал, тэгээд тодорхой хэмжээний энэ ондоо илүү тушаагдах, үндэслэлтэй гэдгээрээ энэ 5 хүртэлх хувиар урамшуулалтай алт авахаар л ийм хуулийн заалт явж байгаа юм.

Ер нь бас ингээд өмнө нь ийм олон улсын нээлт тодорхой бодитой мэдээлэл гарч байсан л даа, Хятадын сонин дээр. Хятадын нэг хотод нэг айл бизнесмен гэртээ алт хураачихсан байсан. Энэ алт хаанаас гарч ирсэн бэ гэхээр бүр нэлээн хэсэг хувь нь буюу 10-н хэдэн тонн алтны 70, 80-аад хувь нь Монголоос ирсэн алт гээд ингээд бас хариултаа өгчихсөн. Тэгэхээр Монголоос бол бас ийм хулгайгаар тодорхой хэмжээний алт гардаг. Ялангуяа Хятадын зах зээл дээр бол дэлхийн зах зээлийн ханшаас өндөр үнээр авдаг гэсэн ийм ийм захын ханш байдаг гэсэн юм. Тэгэхээр тийшээ явуулахгүй байх үүднээс тодорхой урамшууллыг түр зууртаа авч явах боломжтой юм уу гэдгээрээ л энэ төсөл бичигдсэн.

Т.Доржханд: Бууруулж болох уу?

Б.Лхагвасүрэн: Бүр их 10, 20 гэж тавьж болохгүй. Яагаад гэвэл 5 гэдэг тоо бол өөрөө яг өнөөдрийн үнэ цэнээр нь бодох юм бол нэг бараг 150 орчим тэрбум төгрөгийн ийм нэмэлт эх үүсвэр гарах л ийм хэмжээ байгаа юм.

Т.Доржханд: Ханшийн эрсдэл?

Б.Лхагвасүрэн: Ханш дээр бол одоо энэ шинээр үүссэн нөхцөл байдалтай холбогдуулаад ерөнхийдөө нефтийн үнэ бол бидний намар авч байсан үнээс ялангуяа анх репо санхүүжилт хийгээд явж байсан хүнээс бараг 30 хувиар өсчихөөд байна л даа. Тэгэхээр бол ингэж цаашаа нэгдүгээрт нефтийн үнээрээ өсөх, дээр нь бол ханш

ингээд суларч байгаа үед ханш суларч байгаа үед бол мэдээж дахиад дарамт үүсгэх үүднээсээ өнөөдрийнх нь энэ байгаа ханш дээр нь гурван сарын хугацаанд тогтвортой ийм ханш бүрдүүлэх боломж нь байгаа юм. Репо санхүүжилтийн буюу бас энэ үүсмэл хэрэгслээр дамжаад. Тэгэхээр банкнууд ийм үүсмэл хэрэгслээр дамжуулан харилцагчийнхаа ханшийн эрсдэлийг хамгаалж чадвал тэр бас хэрэгслээр нь дамжаад Монголбанк ч гэсэн банкны эрсдэлийг хамгаалах боломж байгаа юм. Энэ хүрээндээ л орж ирж байгаа юм.

Т.Доржханд: Үүсмэл хэрэгслээ тайлбарла даа.

Б.Лхагвасүрэн: Үүсмэл хэрэгсэл гэдэг бол форвард арилжаа, своп арилжаа, эдгээр л дээ.

Ж.Ганбаатар: Доржханд гишүүн тодруулъя.

Т.Доржханд: Тэгэхээр Сангийн сайд аа, энэ төсвийн тодотгол бол тусдаа оруулж ирэх юм байна. Засгийн газраас яаралтай орж ирнэ гэж ойлголоо. Тэр үеэр Улсын Их Хурлын гишүүд холбогдох чиглэлүүдээ өгнө гэж ойлголоо шүү.

Хоёрдугаарт, би Хүрэлбаатар гишүүнтэй бас санал нэг байна. Бид нар өвчнийхөө оношийг сайн тодорхойлох ёстой, тийм биз? Өнөөдөр орж ирж байгаа энэ асуудал маань бас яг энэ онош нь зөв байна уу, яг хариу эмчилгээ нь зөв байна уу гэхэд би эргэлзэж байгаа шүү.

Гуравдугаарт бол, энэ Төв банкны зүгээс өмнө нь авч хэрэгжүүлж байсан буруу бодлогыг дахиж хэзээ ч хийж болохгүй ээ. Үнэ тогтворжуулах хөтөлбөр гэдэг зүйл агуулгаар орж ирсэн. Одоо харин тэр мөнгө хэвлэхгүй гэсэн байдлаар ингээд өөрчлөгдөж байна гэж үзээд энийг дэмжиж байгаа. Гэхдээ ханшийн эрсдэлийг Төв банк хүлээж байсан. Тэр нэг булхай.

Ж.Ганбаатар: Доржханд гишүүний саналыг сайн тусгаж анхаарч ажиллана шүү. Монголбанкны ерөнхийлөгч Их Хурлын даргын өрөөнд болж байгаа хурал руу явж бай. Монголбанкныхан урагшаагаа суугаарай.

Санал хураалт явуулна. Ажлын хэсэг битгий гарч яваад байгаараа, адилхан хурал болж байгаа шүү.

Зарчмын зөрүүтэй санал дээр санал хураана. Гишүүд асуулт асууж дууслаа. Зарчмын зөрүүтэй 10 санал байгаа. Хурдан явна аа. Гишүүд анхааралтай байхыг хүсье.

Олон улсын хямралт нөхцөл байдлаас үүдэлтэй гол нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төслийн талаарх ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя.

ОЛОН УЛСЫН ХЯМРАЛТ НӨХЦӨЛ БАЙДЛААС ҮҮДЭЛТЭЙ ГОЛ НЭР ТӨРЛИЙН БАРАА, БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНИЙН ӨСӨЛТ, ХОМСТЛООС СЭРГИЙЛЭХ, СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ АЖЛЫН ХЭСГЭЭС ГАРГАСАН ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ

1.Төслийн гарчгийн “Олон улсын хямралт нөхцөл байдлаас үүдэлтэй” гэснийг хасах. Энэ саналтай холбогдуулан төслийн 1.1 дэх хэсэгт заасан хуулийн зорилгод байгаагаас бусад төслийн зүйл, хэсэг, заалтад байгаа “олон улсын хямралт нөхцөл байдлаас үүдэлтэй” гэснийг хасах.

Санал гаргасан ажлын хэсэг

Санал хураалт. Гишүүд анхааралтай байхыг хүсье.

Хүрэлбаатар гишүүн дэмжиж санал өгсөн.

2.Төслийн 5.1 дэх хэсгийн “банктай хамтран” гэснийг хасах. Чухал санал шүү. Хүрэлбаатар гишүүний бас гаргаж байгаа.

Санал хураалт. Санал дэмжигдлээ.

3.Төслийн 5.1.1 дэх заалтын “банкаар дамжуулан олгох” гэснийг “банкны эх үүсвэрээр олгох” гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг

Санал хураалт. Санал дэмжигдлээ.

4.Төслийн 5.1.2 дахь заалтын “хөнгөлөлттэй санхүүжилтийг банкаар дамжуулан” гэснийг “санхүүжилтийг репо арилжааны нөхцөлөөр банканд” гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг

Санал хураалт. Санал дэмжигдлээ.

5.Төслийн 5.1.3 дахь заалтыг “санхүүгийн үүсмэл хэрэгсэл ашиглан энэ хуулийн 3.2.1-д заасан бараа, бүтээгдэхүүний импортод шаардлагатай гадаад валютыг ханшийн эрсдэлийг бууруулж импортлогчдод нийлүүлэх бөгөөд банк энэ эх үүсвэрээр ашиг олох зорилгоор арилжаа хийхийг хориглох,” гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг

Доржханд гишүүн.

Санал хураалт. Санал дэмжигдлээ.

Т.Доржханд: Энэ дээр ажлын хэсэг дээр яриад өчигдөр байх тийм ээ, бид нар энийгээ хасъя гэсэн шүү дээ. Тэгээд жаахан найруулга нь өөр болоод ирчихсэн байна. Тэгэхээр өмнөх тэр муу алдаа гээд байдаг нь юу вэ гэхээр энэ үүсмэл хэрэгсэл буюу 0 хувийн хүүтэй своп гэрээ байгуулаад газрын тос импортлогч нарын өгч байгаа мөнгийг доллар болгоод тэгээд гурван жилийн дараа яг өнөөдрийнхөө ханшаар буцааж авна гэдэг ийм агуулгаар яваад байгаа байхгүй юу. Тэгээд яг ийм агуулгаар өмнө нь 2012-2016 онд асар их хэмжээний хулгай луйвар, шамшигдал явсан. Тэгээд энийг би ажлын хэсэг дээр ярьсан. Ажлын хэсгийг гишүүд бүгдээрээ дэмжээд, тэгвэл энийгээ хасъя, харин ханшийн эрсдэлийг юугаараа орлуулж болох вэ гэдэг дээр. Тэгвэл үүн дээр бид нар татаас өгөх байдлаар хөнгөлөлт үзүүлж байгаа юм чинь энэ эрсдэлийг тооцож байгаад тэр хөнгөлөлтдөө нэг мөр оруулаад явъя гэсэн байдлаар бүгдээрээ санал нэгдсэн гэж ойлгож байгаа. Тэгээд одоо энэ дээр болохоор хуучнаараа ороод ирсэн байна. Тийм болохоор энэ дээр асууж байна. Яагаад ингээд ороод ирэв?

Ж.Ганбаатар: Санал гаргавал бичгээр гаргаж өгнө.

Т.Доржханд: Тэгвэл бичгээр бичээд өгчихье. Хариултаа авчихъя.

Ж.Ганбаатар: Нэг ажлын хэсгийн гишүүн ажлын хэсгийн даргаасаа асууж байна. Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Доржханд гишүүний санаа зовсон үндсийг нь бол ойлгож байгаа. Тэгэхдээ тэрийг бол шийдэж оруулж ирж байгаа юм биш шүү. Би энд тайлбарлах гээд оролдъё. Өмнө нь арбитражийн зорилготой буруу ашиглаад явчихсан бол энэ заалтаараа ямар тийм ч боломжгүй болж ирж байгаа юм. Төв банк зөвхөн банк хоорондын зах дээр л ажилладаг. Шууд импортлогч нартай бол арилжих ямар ч боломж байхгүй. Тэгэхээр банк тэнд зуучлагчийн үүрэг л гүйцэтгэнэ. Шатахуун импортлогч нар захиалгыг нь аваад бараг л ер нь зөвхөн 92 нийлүүлэхэд л захиалгыг нь аваад, өнөөдөр 2 сая доллароор, 3 сая доллароор захиалга хийх гэж байгаа юм гэвэл гэрээг нь харж байгаад банк тэр захиалгыг Төв банк руу дамжуулна. Төв банк тэр хэмжээгээр нь хэрэглэнэ. Ямар арилжаа хийх юм, банк өөрөө Төв банк өөрсдөө сонгодог. Тэгээд нэг форвард л хийж таарах байх. Своп хийх нь үү, тэгээд өгнө. Тэр дунд банк бол зөвхөн дамжуулах л үүрэг гүйцэтгэнэ. Арилжаанд оролцож байгаа, энэ бол арилжаа. Гэхдээ ашиг олох зорилгоор хийхгүй шүү, зөвхөн дамжуулна шүү гэдгийг л энүүгээр маш нарийн зааж өгч байгаа юм. Тэгэхээр цаад импортлогч дээр ямар нэг зөрүү нэмэгдэхгүйгээр Төв банкны ханшаар нэг хэсэгтээ импортлогч нар шатахуунаа татаж авна гэсэн үг.

Ж.Ганбаатар: Уучлаарай тодруулга гэж дэгд байхгүй байна. Энэ чинь асуулт хариулт биш, зарчмын төртэй санал учраас. Уул нь бол танаар бүр ч асуулт асуулгахгүй байх ёстой. Ажлын хэсгийн гишүүн учраас. Уучлаарай, Цэрэнпунцаг гишүүн асуулт асууя.

Ц.Цэрэнпунцаг: Жавхаа сайд аа, энэ яг ямар хэрэгсэл ашиглах юм гэдгээ яг тодорхой энэн дээр заачхаж болохгүй юм уу? Одоо энэ 5.1.3 байна. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл ашиглана гэдэг чинь энэ дээр яг ямар механизм ашиглах юм гэдгээ энэ дээр тодорхой заагаад өгчихвөл. Энэ чинь, харин цөөхөн гэдгээ тэд нарыгаа тоочоод ч юм уу. Тэгвэл энэ дээр янз бүрийн нэг ийм хардалт.

Ж.Ганбаатар: Цэрэнпунцаг гишүүний асуултыг ойлгосон уу? 3 номер, хоёр минутад багтаагаад хариулъя. Энэ чинь зарчмын зөрүүтэй саналаар санал хурааж байгаа. Асуулт, хариулт бол дуусчихсан шүү дээ.

А.Энхжин: Цэрэнпунцаг гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр 2012-2016 оны хооронд хооронд хийж байсан тэнцүү хүүтэй үүсмэл хэлцлүүдийг Монголбанк ерөнхийд нь бүгдийг нь зогсоогоод, одоо яг зах зээлийн зарчмаараа своп, форвард хэлцлүүд банкнуудтай байгуулаад энэ манай энэ хэрэгсэл бүгдэд нь нээлттэйгээр хэрэгжээд явж байгаа. Тэгэхээр зөвхөн энэ хэрэгслийнхээ хүрээнд л шатахууны импортлогчдод ханшийн хэрэгсэл үүсэхээс сэргийлэх зорилгоор энийгээ чиглүүлж ажиллая гэсэн санал байгаа юм. Тэгэхээр таны хэлснээр бол ер нь манай богино хугацаатай своп, форвард хэлцлүүд л гэсэн үг.

Ж.Ганбаатар: Энэ эх үүсвэрээр гэдгийг сая Энхбаяр гишүүний саналаар орлоо шүү дээ.

Санал хураалт явуулъя.

Санал дэмжигдлээ.

6.Төслийн 6.1.2 дахь заалтын “жилийн батлагдсан нэгдсэн төсвийн нийт зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр төсөв хооронд, төсвийн ерөнхийлөн захирагч

хооронд, хөрөнгийн болон урсгал зардал хооронд төсвийн зохицуулалт хийх замаар шийдвэрлэх” гэснийг “тухайн жилийн төсөвт тусган шийдвэрлэх” гэж өөрчлөх.

Оюунчимэг гишүүн.

М.Оюунчимэг: Жавхлан сайд аа, одоо КОВИД-ын хууль 12 сарын 31 хүртэл үйлчилж байгаа. Энэ хууль өөрөө бас 2022 оны 12 сарын 31 гэж орж ирж байгаа байх тийм ээ? Тэгэхээр энэ дээр төсвийн ерөнхий захирал ч хооронд хөрөнгийн болон урсгал зардал хооронд төсвийн зохицуулалт хийх замаар шийдвэрлэх гэдгийг тухайн жилийн төсөвт тусган шийдвэрлэх гээд өөрчилж байгаа юм байна л даа. Энэ хуулиар. Гэтэл КОВИД-ын хуулиар болохоор төсөв захиран зарцуулагч нар хоорондоо ингээд гүйлгээд мөнгө зарцуулах эрх нь түүгээр нээлттэй байгаа шүү дээ. Тэгэхээр энэ хоёр хууль ингээд үйлчлээд явах юм уу? Алийг нь илүү н нэгд үйлчилгээ юм.

Төсвийн тодотголоор бол 2022 оны төсөвт тодотгол хийгээд тухайн жилийн төсөвт тусгасан гэдгээр ингээд явчихна. Гэтэл КОВИД-ын хууль дээр ийм байгаад байгаа. Хоёулаа хүчин төгөлдөр үйлчлээд байгаа шүү дээ. Яаж энийг зохицуулах вэ? Алийг нь үндсэн хууль гэж харж үзэх вэ? Энэ дээр зарим сайд нар чинь тэгээд л өөр хийгээд л явчихна шүү дээ.

Ж.Ганбаатар: Жавхлан сайд гишүүний асуултад хариулъя.

Б.Жавхлан: Оюунчимэг гишүүн ээ, хамаагүй халих гэж байна шүү. Зарим сайд нар чинь энэн дээр яг юу хийж байна гэхэв ээ? Болохгүй шүү. Одоо сайд нар гэхээр бүгдээрээ болж бүтэхгүй юм хийдэг юм шиг. Бид нар чинь бас хяналт тавиад явна шүү дээ. Энэ асуудлаар Төсвийн байнгын хорооны даргатайгаа ярьж ойлголцсон. Тэгээд энэ заалтыг энэ хууль дээрээсээ хасаад, төсвийн тодотгол дээрээ оруулж ирээд тэгээд шийдчихье гэж байгаа юм. Тэгэхээр энэ дээр бол төсвийн харилцаатай үүсэх тийм зүйл заалтуудаа авчхаж байгаа гэсэн үг.

Ж.Ганбаатар: Ажлын хэсэг дээр наадахаа яриад шийдэхгүй, одоо ч санал хураалт явж байгаа. Тэгэхээр би санал ямар ч байсан санал хураалгая. Дэмжих, дэмжихгүйгээ гишүүд өөрсдөө мэднэ биз. Өөрчилчихсөн юм байгаа биз дээ? Өөрчилчихсөн юм байна гэж ойлголоо, Булгаа зөв үү?

Санал хураалт. Гишүүд анхааралтай байхыг хүсье.

Санал 76.9 хувиар дэмжигдлээ.

7.Төслийн 6.1.3 дахь заалтыг хасах.

Санал хураалт. Санал дэмжигдлээ.

8.Төслийн 6.1.5 дахь заалтыг хасах.

Санал хураалт. Санал дэмжигдлээ.

9.Төслийн 6.1.1, 7.1.1 дэх заалтын “бүтээгдэхүүний” гэсний дараа “үнийн өсөлт,” гэж тус тус нэмэх.

Санал хураалт. Санал дэмжигдлээ..

10.Хууль, тогтоолын хүчин төгөлдөр болох хугацааг 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдрөөс гэж өөрчлөх.

Санал хураалт. Санал дэмжигдлээ.

Найруулгын саналаар гурван санал байна.

1.Төслийн гарчигт “төрлийн” гэсний дараа “зарим” гэж, 5.1, 6.1, 7.1, 8.1 дэх хэсгийн “хэрэгжүүлнэ.” гэсний өмнө “авч” гэж, 5.1 дэх хэсгийн “гол” гэсний өмнө “энэ хуульд заасан” гэж тус тус нэмэх.

Санал хураалт. Санал дэмжигдлээ.

2.Төслийн 3.1 дэх хэсгийн “эдгээр бүтээгдэхүүнтэй хамаатай” гэснийг “эдгээртэй холбогдсон” гэж, 3.2 дахь хэсгийн “доор дурдсан” гэснийг “заасан гол нэр төрлийн зарим” гэж, мөн хэсгийн “бүтээгдэхүүн” гэснийг “бүтээгдэхүүнд дараах бараа, бүтээгдэхүүн” гэж, 7, 8 дугаар зүйлийн гарчгийн “байгууллагын” гэснийг “байгууллагаас” гэж, 8.1.1, 8.1.2 дахь заалтын “хуульд заасан зохицуулалтад хамрагдсан” гэснийг “хуулийн 3.2.2, 3.2.3-т заасан” гэж, 8.1.1 дэх заалтын “хүнсний хангамж,” гэснийг “хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт, хангамж,” гэж, 7.1.2, 8.1.3 дахь заалтын “мөрдүүлэх” гэснийг “, биелэлтийг ханган ажиллах” гэж, 6.1.6 дахь заалтын “мөрдүүлэх ажлыг зохион байгуулах” гэснийг “, биелэлтийг хангуулан ажиллах” гэж тус тус өөрчлөх.

Санал хураалт.

3.Төслийн зүйл, хэсэг, заалт хасагдсантай холбогдуулан дугаарлалтыг өөрчлөх болон төслийн агуулгыг хөндөхгүйгээр хууль зүйн техникийн болон найруулгын шинжтэй засвар хийх.

Санал хураалт. Санал дэмжигдлээ.

Санал хураалт явуулж дууслаа.

Олон улсын хямралт нөхцөл байдлаас үүдэлтэй гол нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний хангамжийн нийлүүлэлтийн хомстол, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх санал, дүгнэлтийг Улсын Их Хуралд ажлын хэсгийн ахлагч Булгантуяа гишүүн танилцуулна. Ажлын хэсэгт баярлалаа.

Дараагийн асуудалдаа оръё.